

БӨХӨНГИЙН МЭДЭЭ

Бөхөнгийн экологи ба хамгааллын талаар мэдээлэл солилцох 6 хэл дээрх хэвлэл

Устюртын тал нутгийн бөхөнгийн хууль бус агналттай тэмцэхэд уран хатгамалыг ашиглах нь

Петер Дамарелл, Елана Быкова & Е.Ж. Милнер Гулланд

Зөвлөх редактор: Петер Дамарелл, Бөхөн хамгаалах нийгэмлэг, Peterdamerell@hotmail.co.uk



Зургийг Петер Дамарелл

Ядуурал, ажилгүйдэл нь бөхөнг хууль бусаар агнах түлхүүр хүчин зүйл юм. Устюртын өндөрлөг дэх хязгаарлагдмал ажлын байрны олоц нь ядуу хүмүүст бөхөнгийн агналтаас тодорхой хэмжээний санхүүгийн орлого олох боломжтой болгодог. Түүнчлэн ядуу зүдүү байдал нь харьцангуй хямд бөхөнгийн мах нь орон нутгийн хүнсний хэрэгцээг хангадаг байна.

Бөхөн хамгаалах нийгэмлэг нь жаслык болон Каракалпак тосгоны эмэгтэйчүүдэд уламжлалт арга техникийг зааж сургах уран хатгамалын 2 төвийг байгуулах ажлыг дэмжсэн. Эдгээр төвүүд нь бөхөн хамгааллын тухай орон нутгийн хүмүүст мэдээлэл өгөх боловсролын төв байгаад зогсохгүй уран хатгамалын бүтээгдэхүүнийг зарж борлуулах бизнесийн үйл ажиллагааг үзүүлнэ. Эмэгтэйчүүд орон нутгийн өрхийн төсвийг бүрдүүлж, нэмэлт орлогын эхүүсвэртэй болсоноор эерэг хандлага нэмэгдэж эмэгтэйчүүд хэзээ ч бөхөнгийн мах худалдаж авахгүй, үүнийг хийх санхүүгийн шаардлага байхгүй болно хэмээн таамаглаж байсан. Хоёрдахь үр ашиг нь энэхүү үйл ажиллагаанд оролцож байгаа эмэгтэйчүүд өөрсдийн хамаатны эрчүүдийн бөхөнгийн хууль бус анд оролцох явдлыг хориглох болно хэмээн тооцоологдсон.

Эдгээр зорилтууд руу чиглэгдсэн үйл ажиллагааг дэвшилд хүргэхийн тулд анализ хийгдэж байна. Энэхүү анализ нь урт хугацаанд өөрийгөө авч явах чадвартай хөтөлбөр, тэдгээрийн хамгааллын нөлөө зэрэг уг схемийн хүч чадлыг нэмэгдүүлэхэд оршино (Хүснэгт 1).

Үр ашиг ба зах зээлийн хэрэгцээ: Одоо энэхүү уран хатгалмалын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зардлыг олохын тулд Бөхөн хамгаалах нийгэмлэгээс олгодог тэтгэлэгт найдсаар байна. Үр ашигтай байдал нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тулд зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлсэнээр өсөх боломжтой.

Үргэлжлэл 2-р хуудсанд

Энэхүү хэвлэлийг ивээн тэтгэсэн:

Агуулга

Гол мэдээ

Петр Дамарелл ба бусад.

Устюртын тал нутгийн бөхөнгийн хууль бус агналттай тэмцэхэд уран хатгамалыг ашиглах нь 1

Шинэ мэдээ

Бахытбек Дусекеев

Хулгайн анчдын эсрэг тэмцэл..... 5

Анатолий Клюднев

Степной БНГ-т өрнөж буй амьдрал 5

Евгений Авраменко

Бөхөн: Кинонны үнэн амьдралын түүх..... 7

Гулмира Изимбергенова

Казахстанд хийгдэж буй ухуулга сурталчилгааны өргөн хүрээтэй хэвлэл мэдээллийн кампанит ажил..... 8

Елена Быкова&Севера Шаранова

Бөхөн томоохон үзүүлэн болж байна..... 9

Елена Быкова

Узбекстанд хэрэгжиж буй утга зохиол, урлагийн экологийн боловсрол олгох шинэ төсөл 10

Б.Батхуяг&Б. Чимэддорж

Монгол Хятадад бөхөнгийн эд эрхтний хил дамнанс худалдааг хязгаарлах нь 11

Хэвлэлийн мэдээ

Волга Уралын бөхөнгийн популяцийг хамгаалах хэлэлцээр Орос, Казахстан улс гарын үсэг зурлаа. 12

Халимагт бөхөн агнуурыг хорив.

Казахстаны шинээр байгуулагдсан байгалийн нөөц газар хоёрдахь Серенгети болохоо амлав.

НҮБХХ Оросын бөхөнг хамгаалахаар ажиллаж байна.

Өгүүлэл

Алберт Салемгареев

Устюртын бөхөнгийн популяцийг хамгаалах, судлахад сансрын дохиолол дамжуулагчийг ашиглах нь 14

Антоний Дансер ба бусад.

Казахстаны баруун хэсгийн бөхөнгийн үхлийн бодит шалгаанд хийсэн зайнаас тандах болон in situ анализ 16

Жое Булл&АдександерЕситов

Устюртын бөхөнг агнах эртний арга хэрэгсэл: аррансын үлдэгдэл... 18

Зарлал

Бөхөн хамгаалах нийгэмлэг, Жижиг тэтгэлгийн уралдаан, 2012..... 20

“Бөхөн гөрөөсний харилцан ойлголцлын санамж бичгийн зохицуулга, хэрэгжилтийг хангах” хурал болон Бөхөн хамгаалах нийгэмлэгийн жил тутмын уулзалт..... 20

Бөхөнгийн баатрууд

Б.Батсайхан, Монгол 20

Үргэлжлэл 1-р хуудсанд:



Өнөөгийн байдлаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнүүд нь Нукус дахь уран хатгамалын төв, Ташкент дахь уран хатгамалын дэлгүүр болон Зэрлэг амьтан хамгаалах сүлжээний үзэсгэлэн худалдаагаар борлуулагдсан. Уран хатгамалын хөтөлбөрт оролцож буй эмэгтэйчүүд одоогийн хүлээн авсанаас илүү өндөр үнэд нийцсэн чанар сайтай янз бүрийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг бөгөөд энэ нь Европ болон АНУ-д бүрэн дүүрэн боломжтой ихээхэн үр ашигтай зах зээл юм.

Дэд бүтэц: Уран хатгамалын сүлжээ нь харьцангуй бага эхлэлийн хөрөнгөтэй эхэлсэн бол одоо тэдгээрийн хөрөнгө нэмэгдэж байна. Жаслык бүлэг нь тосгоны сургуулийн ангийг ашиглаж байсан бол Каракалпак бүлэг 20 орчим уран хатгамалч байрлаж чадах шинэ өрөөг тохижуулсан байна.

Орон нутгийн иргэдийн ур чадвар, нэгдмэл байдал: Уг схемийн үнэлэмж өндөр байна. Уг үйл ажиллагаа нь соёлын үүднээс ихээхэн үр дүнтэй бөгөөд уран хатгамал бол бүх насны Узбек эмэгтэйчүүдийн дунд нийтлэг үйл юм. Уран хатгамалын хөтөлбөр нь материалын олдоц, боломж, орон нутгийнхны мэдлэгээс шалтгаалан нарийн нийлмэл байдал нь маш доогуур түвшинд байна. Төлөвлөгдсөн ирээдүйн нарийн нийлмэл бүтэц нь зах зээлд танигдаж эхлэх үед уг бүтээгдэхүүнийг тохиромжтой зах зээлд нийлүүлэлт нь өснө.

Хамгаалалд холбогдох нь: Одоогийн байдлаар уран хатгамалын төв нь уламжлалт соёл, орон нутгийн иргэдийн хувьд чухал газар болох нь харагдаж байгаа хэдий ч тэдгээрийн ажлыг бөхөн хамгааллын ажил руу чиглүүлэх нь илүү хүнд асуудал билээ. Асуулгад хамрагдсан хүмүүсээс зөвхөн 3 уран хатгамалчин л уг хөтөлбөрийн түлхүүр зорилго нь бөхөнг хууль бусаар агнах явдлыг багасгах хэмээн тодорхойлсон ба тэдгээрийн хамаатан саднууд энэхүү хөтөлбөр хэрэгжиж байгаагийн томоохон шалтгаан нь энэ асуудал болохыг онцлон тэмдэглэжээ.



Хүснэгт 1.

Хамгааллын схемд суурилсан амжилттай ажиллаж буй орон нутгийн бүлгийг тодорхойлох шалгуурт уран хатгамалын амьжиргааны эх сурвалжийн боломжит байдал. Хориглох болон анхаарах шаардлагатай газруудыг тод үсгээр бичсэн.

Хүчин зүйл	Сайн төлөв байдал	Муу төлөв байдал	Уран хатгамалын хөтөлбөр
<i>Ажил хэрэг</i>			
Үр ашигт байдал	Зардлаас илүү орлоготой	Зардлыг нөхөж чадахгүй байх	Зардлыг нөхөж чадахгүй
Зах зээлийн эрэлт	Дунд зэргийн	Маш их ба маш бага	Маш бага
Дэд бүтэц	Сайн	Муу	Боломжийн ба сайжруулж байгаа
Орон нутгийн ур чадвар	Өндөр	Муу	Өндөр
Нийлмэл бүтэц	Бага	Их	Бага
Хамгаалалд холбогдох байдал	Өндөр	Бага (эсвэл ойлгоогүй)	Ухамсарлаагүй
<i>Үр ашиг</i>			
Бэлэн мөнгөний ашиг	Дунд зэргийн	Маш их ба маш бага	Маш бага
Бэлэн мөнгөний бус ашиг	Их	Хязгаарлагдсан	Их
Түгээлт	Тэдгээрийг хамгаалах зорилгууд	Хэт өргөн / буруу хүмүүс	Эмэгтэйчүүд гэр бүлд нөлөөлөх хэмжээнд хүрч чадахгүй
<i>Оролцогч талууд</i>			
Удирдагч	Тэнцвэртэй & хүндэтгэгдсэн	Байхгүй эсвэл хэт хүчирхэг	Тэнцвэртэй & хүндэтгэгдсэн
Бүлгийн нэг ижил байдал	Бүрэн дүүрэн	Хязгаарлагдмал	Хүчирхэг
Өрсөлдөөн	Байхгүй	Байгаа	Байхгүй
Бусад			
Төслийн холбоо	Туршлагажсан & зохион байгуулагдсан	Эсрэгээр	Зохион байгуулагдсан

Оролцогчийн гэр бүлийн санхүүгийн үр ашиг нэгдүгээрт байх ёстой гэж нэг ч хүн хариулаагүй. Бөхөн хамгааллын үндсэн зорилго нь ихээхэн өндөр түвшинд хүрсэн болохыг тодорхой харуулна. Жаслык уран хатгалмалын бүлэгт жилмийн турш, гэрлэх хүртлээ хамрагдаж байсан. Албан ёсны гишүүн эмэгтэй “*Бөхөн хамгаалах нийгэмлэг, уран хатгамалын бүлгийн хооронд ямар холбоо байна вэ, уран хатгамал бөхөнд хэрхэн тусалж чадах вэ?*” гэж асуусан. Оролцогчдод тодорхой зорилгыг хөтөлбөрт бий болгох нь бөхөн хамгаалалд уран хатгамалын бүлгийн үйл ажиллагааг чиглүүлэх эхний алхам юм.

Бэлэн мөнгөний ашиг: Хязгаарлагдмал орон нутгийн зах зээлд байснаар уран хатгамалчдын хүлээн авах санхүүгийн эх сурвалж мөн хязгаарлагдмал байна. Гар урлалын бүтээгдэхүүнүүд нь маш бага мөнгө олохын тулд маш их цаг хугацааг шаарддаг. “*Охидын хийж байгаа зүйл асар их мөнгө бус, маш өчүүхэн бэлэн мөнгө болдог.*” Бөхөнгийн махны үнийг үхрийн махтай харьцуулан үзвэл худалдан авах махны чанараас шалтгаалан сард 36,000 Сом (~\$18) ба 84,000 Сом (~\$42) хүрдэг. Энэ нөхцлийг орон нутгийн 4 айлын мэдээллийг дундажлан тооцсон.



Диаграмм 1.

Харилцан адилгүй оролцооны стратегийн таамаглагдсан учир шалтгааны холбоосууд



Зургийг: Александр Естинов

Жаслык уран хатгамалын бүлгийн гишүүн бүлгийн гишүүдийн хийсэн га утасны хатгамал уутыг харуулж байна.

Энэ судалгаанд оролцогч гэр бүлийн дундаж хэмжээ нь 5,5 байсан бол уран хатгамалаас олох нэмэлт орлогын дундаж хэмжээ нь сард 10 ам доллар байна. Иймээс хөтөлбөрт оролцогчдын өнөөгийн авч буй мөнгөний хэмжээ нь бөхөнгийн махыг бус үхрийн махыг худалдан авахад хүрэлцээгүй байна.

Бэлэн мөнгөний бус ашиг: Оролцогчид уран хатгамалын бүлгийн тухай эерэг ойлголттой болсон бөгөөд энэхүү шийл ажиллагаанд оролцож байгаадаа баяртай байсан.

Түгээлт: Уран хатгамалчдын дийлэнх хэсэг нь 18-аас доош насныхан буюу сургуульд суралцдаг байна. Үндсэн хатгамалчид хөтөлбөрийг орхин явсан үндсэн шалтгаанаа гэрлэлтийн улмаас цаг хугацаа хомс байсантай холбон тайлбарласан. Энэ нь Устюртын эмэгтэйчүүд залуу насандаа, хорь хүрэнгүүт гэрлэдэг нь гол асуудал юм. Үүний дараа тэд өрхийн орлогийн зарим хэсгийг хянан зарцуулж эхлэдэг ба эрэгтэй хамаатан саднуудтай холбоотой болон мах худалдан авах шийдвэрийг гаргах боломжтой болдог. Өнөөгийн байдлаар уран хатгамалын хөтөлбөрийг орхин явж байгаа оролцогчид хөтөлбөрийн зорилго дээр суурилсан үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлэх боломжтой байна.


Нэн ядуу өрхийн цөөн тооны оролцогчид бөхөнгийн хуулт бус анд илүү их оролцдог ба өөр нэмэлт орлогын эх үүсвэрт илүү уриалгахан болсон байна. Каракалпакид уг хөтөлбөрийг илүү өргөн хүрээг хамруулан сурталчилж байгаа бөгөөд дунд насны эмэгтэйчүүд, ядуу дүүргийн хүмүүс, хууль бус ан хийдэг өрх бүхий сэжигтэй газар нутгаас айл өрхийг хамруулан өргөжүүлэх чиглэлээр тэргүүлж байна.

Удирдлага: Удирдлага нь хөтөлбөрийг хүчирхэгжүүлэх түлхүүр юм. Удирдагч нар нь хүчирхэг бөхөн хамгаалах сонирхолд хөтөлөгдсөн байх ёстой. Орон нутгийн удирдагч нар нь өөрсдийн бүлгүүдийн хооронд хүчирхэг харилцаа холбоог байгуулах бөгөөд хөтөлбөрийг өргөжүүлэн үргэлжлэх боломжтой бизнес рүү орох сонирхлыг хадгалсаар байна. “Хэрвээ тэнд бөөн хүмүүс байсан бол би хичээл бүрт 20 сурагчтайгаар өдөрт 2 удаа хичээл орж чадах байсан. Би 7 хоногийн 5 өдөр нь чөлөөтэй байсан”.

Бүлгийн ижил төст байдал ба өрсөлдөөн: Өнөөгийн уран хатгамалын хөтөлбөрт оролцож буй янз бүрийн сонирхолын бүлгүүд уран хатгамалын чадварыг суралцсанаар хөтөлбөрт хамрагдан нийгмийн нөхцөл байдалд анхааран бүгд баяр хөөртэй байсан. Орон нутгийн иргэд уг нутгийг сонирхож буй гадны байгууллагын төлөөллийг харсандаа, энэхүү ач холбогдолтой төслийг бий болгоход тусалж буйд ихээхэн баяртай байсан. Орон нутгийн хөгжилд үзүлж буй улс төрийн дэмжлэг байгаа.

Төслийн холбоо: Уран хатгамалын төвд суурилсан Нукус, бөхөн хамгаалал руу чиглэгдсэн эрдэм шинжилгээний ажилтан судлаачдын хоорондын холбоо урт хугацааны хамтын ажиллагааны үр дүнд бий болох болно. Хөтөлбөрт оролцож буй бүх талуудад үр ашигтай байх хүчирхэг, урт хугацааны харилцаа холбоо бий болж чадахгүйг төсөөлөх шалтгаан үгүй.

Хэдийгээр уг хөтөлбөрийн санхүүгийн асуудал нь ихээхэн анхаарал татсан асуудал бөгөөд хамгийн чухал үр дүн нь хөтөлбөрийн боломжит хамгааллын нөлөөг ойлгох асуудал юм. Эдгээр ажил үйлстээ бие сэтгэлээ зориулсан удирдлага, оролцогчдын гинжин цувааны үр дүнд уг төсөл нь хүчирхэг эх үүсвэр юм. Уг хөтөлбөрийн эдгээр эрүүл эх үндсийг байгуулах нь Узбекистанд бөхөн хамгаалалд чухал үүрэгтэй байх болно.



Диаграмм 2.

Уран хатгамалчид, тэдгээрийн хамаатан саднуудын уран хатгамалын хөтөлбөрийн үндсэн зорилгыг ухамсарласан байдал. Асуулгад хариулагчид 5 асуулгаас “Энэ нь гэр бүлийн нэмэлт орлогыг хангана” гэсэн хариултыг сонгосон бол үлдсэн нь энэ хариултыг сонгоогүй байна.

Сүүлийн үеийн мэдээ

Хулгайн анчдын эсрэг тэмцэл

Бахытбек Дуйсекеев

Казахстаны БНУ-ын ХАА-н яам, Ой, ангийн менежментийн зөвлөл, Амьтны хэлтэс, cites@minagri.kz

2012 оны эхний 10 сарын байдлаар Казахстаны бөхөнгийн тархац нутагт бөхөн агнасан, бөхөнгийн эвэр худалдсан, худалдан авсан 24 зөрчил бүртгэгдсэн ба түүнчлэн 131 гулууз мах, 5486 эвэр (ихэвчлэн хээрээс цуглуулсан хуучин эвэр) хураагджээ. Эдгээр тоо баримт, түүнчлэн электрон хэлбэрээр болон хэвлэмэл байдлаар тараагдсан бөхөнгийн эвэр худалдан авах зарлалууд нь Казахстанд бөхөнгийн гаралтай бүтээгдэхүүний хууль бус худалдаа, тэдгээрийг хилийн чанад руу зөөвөрлөх явдал бодитой оршин байгааг нотолж байна. Энэ бүхэн нь Төрөөс авч хэрэгжүүлж буй бөхөн хамгааллын арга хэмжээний үр бүтээмжийг үгүйсгэж байна.

Казахстаны БНУ-ын Засгийн газрын 2012 оны 7 сарын 25 өдрийн №969 тоот тогтоолоор 2020 он хүртэл Казахстаны БНУ-ын нутаг дэвсгэрт бөхөн, түүнээс гаралтай эд эрхтнийг ашиглахыг хориглох тухай шийдвэр батлагдсан. Ой, ангийн менежментийн зөвлөл Бодлого боловсруулах төвтэй хамтран Дотоод хэргийн яамны удирдлаган дор БНУ-ын эрүүгийн болон захиргааны хуульд холбогдох өөрчлөлт, нэмэлт зүйлүүдийг оруулсан.

Энэхүү хууль тогтоомжийг хүчирхэгжүүлснээр 2011 онд 12 тохиолдол тэмдэглэгдсэн бол 2012 онд 18 тохиолдол болон нэмэгджээ. Зөвхөн нэг жишээ дурдахад 2012 оны 4 сард бөхөн хууль бусаар агнасны төлөө хулгайн анчид 2012 оны 7 сарын 19-нд болсон Кызылорда аймгийн Кармакши дүүргийн шүүхээс 2-2,6 жилийн хорих ял авсан байна. Нэмж хэлэхэд, хулгайн ангийн үед ашиглаж байсан машиныг хураан авсан. Түүнчлэн 2012 оны 6 сард 63 бөхөн буудсан хулгайн анчдыг Актюбинск дүүргийн Айтекеби дүүргийн шүүх 2012 оны 10 сарын 8 нд 2 жил хорих ялаар шийтгэсэн байна. Хоёр Toyota Land Cruiser машин, буу, бусадэдзүйлсийг хураанавсан.



Зурвалж: Казахстаны БНУ-ын ХАА-н яам

Хүрээлэн буй орчны хууль тогтоомжийг зөрчсөн зөрчлүүдийг хориглон нийгмийн ач тусыг өгч буйг гэмт хэрэгтнүүд өөрсдийн үйл ажиллагааны хариуцлагыг хэрхэн хүлээж байгааг харуулан, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хулгайн ангийн хэрэгт хүлээлшэх хууль эрх зүйн орчныг тодорхой тооцох хэрэгтэй.

Редакторын зурвас: Энд бичигдсэн мэдээнээс эхлэн, шинэ хуулийн дагуу бөхөнгийн хулгайн анчдын тохиолдлыг 50 гаруй бөхөнгийн гулуузны хэргийг оролцуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж байгаа бөгөөд мэдээлжээ..

Степной БНГ-т өрнөж буй амьдрал

Анатолий Клюднев,

2012 он Степной БНГ-ын албан хаагчдад маш чухал жил байлаа. Уг нөөц газар 12 удаа өөрчлөгдсөн (Астрахан дүүргийн захирагч А.П.Гузвины шийдвэрээр 2000 онд байгуулагдсан) ба бид өнөөдрийг хүртэл өөрсдийн хүрсэн амжилтыг эргэн харж дүгнэхийн тулд энэ боломжийг авсан. Энэ хугацаанд нөөц газрын албан хаагчид хулгайн антай тэмцэх, бөхөн хамгаалахад чиглэгдсэн хатуу чанга зохион байгуулалттай, ажил үйлстээ биеэ зориулсан мэргэжлийн сургагдсан баг далайн чанад дахь хүмүүст нэр төртэйгээр үүргээ биелүүлж ирсэн байна.

Хулгайн ангийн эсрэг үйл ажиллагааг нөөц газарт хууль бус үйлдлүүдийн эрчмийг багасгасан байна. Хулгайн анчид манай баг тэднээс бөхөн хулгайгаар агнахыг хориглодог болохыг мэднэ.

Эргүүл хийхийн сацуу Астраханд амьдарч буй янз бүрийн насны хүмүүс, Оросын өнцөг булан бүрээс болон гадаадаас ирсэн олон тооны зочлодог хүрээлэн буй орчны боловсрол олгох, сурталчилгаа хийхэд анхаарлаа хандуулан зүтгэж байна.

In addition, the grant confirmed that our work is absolutely necessary and is highly valued by our colleagues and by conservation donors.

Under the resolution of the Government of the Astrakhan Region, the Stepnoi reserve's 87,000 hectare area is split into two zones; a zone for sustainable land use (34,000 ha) and a zone for saiga conservation and reproduction (53,000 ha) where livestock grazing is completely forbidden. In July 2012, the Stepnoi reserve received a Certificate from the Russian Federation giving it the unlimited right of use of the land in the 53,000 hasaiga conservation zone. This enables us to ensure that the saigas are not disturbed by human activities in this zone.

Зургийг GEO сэтгүүл



Нөөц газарт аялсан Е.Ж. Милнер-Гулландтай хамт Степнойн баг

Бид нөөц газрын дотор амьдарч буй фермерүүдэд хамгаалалтын дэглэмийг чангатгах тухай, ажиглалтын тухай мэдээллийг тогтмол өгдөг. Эдгээр шийдвэрүүд үр дүнгээ өгч нөөц газрын дүрмийг зөрчих тоо нь анх байгуулагдсан хэдэн жилийнхээс харьцангуй бага болсон байна. Бид фермерүүдтэй нөхөрсөг хамтын ажиллагааг бий болгохыг эрмэлзэж байгаа бөгөөд тэдний ихэнх нь бөхөн ажиглахад сайн дураараа туслаж байна.

Жилийн туршид манай ажилчид Халимагийн БНУ-ын Хүрээлэн буй орчин, Байгалийн нөөцийн яам, Черные Земли БНГ-ын хамтарсан багийн хамт төллалтийн үед бөхөнг идэвхтэй хамгаалсан. 2012 оны хавар Степной нөөц газрын олонх газарт төллөх үед нь хэн нэгэн саад хийхгүй байх тал дээр анхааран ажилласан.

Энэ жилийн хамгийн чухал үйл явдал нь АНУ-ын Зэрлэг амьтан загас судлалын холбооны (USFWS) санхүүгийн дэмжлэгтэйгээр Бөхөн хамгаалах холбооноос зохион байгуулсан өрсөлдөөнд жижиг тэтгэлгийг олз авсан явдал юм.

Өнөөгийн эдийн засгийн хямралтай хүнд цагт энэхүү дэмжлэг нь нөөц газрын техник хэрэгслийг сайжруулах (бид Patriot машин болон Suzuki мотоцикл авах болно), мөн бидний хулгайн ангийн эсрэг хийх дайралтын тоог нэмэгдүүлэ үр өгөөжтэй болгоход зарцуулагдах болно. Энэхүү төслийн хэсэг болгон бид Степной нөөц газрын байгалийн тухай өнгөт товхимол хэвлэсэн бөгөөд орон нутгийн хүмүүсийн дунд манай байгууллагын таних тэмдгийг сайжруулах уралдаан зарлагдсан.



Зургийг GEO сэтгүүл

Анатолий Клюднев сургуулийн сурагчидтай хамт.

Энэ жил аялагч, сэтгүүлч, судлаач зэрэг олон тооны зочид- нөөц газарт айлчилсан. Ялангуяа Бөхөн хамгаалах нийгэмлэгийн дарга профессор Е.Ж.Милнер-Гулландын айлчлал бидэнд ихээхэн чухал байсан бөгөөд тэрээр бидний ажлыг өндрөөр үнэлж, 1000 гаруй толгой бөхөнгийн сүргийг өөрийн нүдээр харан, бөхөн хамгаалах цаашдын төлөвлөгөө, манай нөөц газар, бөхөнгийн найз болох орон нутгийн хүмүүсийн үүргийн талаар бидэнтэй зөвлөлдсөн.

2012 оны 7 сард Амьтан телевизийн сувгийнхан Амьтны эрүүл мэндийн Олон улсын нийгэмлэгийн тэтгэлгээр (IFAW) бөхөнгийн тухай, Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтан хамгаалах төвд хүмүүс бөхөнг хэрхэн халамжилж буйг харуулсан 3 кино хийсэн (шинэ мэдээний доод хэсгээс хар). Эхний кино Амьтан телевизийн сувгаар 2012 оны 10 сарын сүүлээр гарсан. GEO сэтгүүлийн гэрэл зурагчин, сурвалжлагч нар нөөц газрын байгалийн тухай, бидний ажлын тухай өгүүлэл хэвлүүлэх зорилготойгоор 2012 оны 8 сард айлчилсан.

Дүгнэн хэлэхэд, тархац нутгийн бусад хэсэгт буй энэхүү гайхалтай бөхөн гөрөөсийг хамгаалахад манай хамт олон үр дүнтэйгээр дэмжин ажиллахыг тэмдэглэн хэлэхийг хүсэж байна. Бидний хувьд ОХУ-аас энэхүү цор ганц зүйлийг устаж алга болгохгүй байхад бүх анхаарлаа тавин ажиллах болно.

Зургийг GEO сэтгүүл



Степной нөөц газрын бөхөнгүүд.

Бөхөн: Киноны үнэн амьдралын түүх

Евгений Авраменко,

Амьтан TV суваг, avramenko@1tvch.ru

Жилийн өмнө Амьтан телевизийн сувгийнхан “Бид халамжилна” нэртэй тусгай төслийн хэсэг болгон зэрлэг амьтны тухай кино хийсэн. Амьтны эрүүл мэндийн олон улсын нийгэмлэгтэй удаан хугацаанд хамтран ажилласаны үр дүнд 2012 оны зун тус телевизийн сувгийн хамт олонд зэрлэг амьтдын зураг авах боломж дахин олдсон. Энэ хугацаанд Халимагт, Астраханы бус нутгийн хээр талд хүрэх ховордсон бөхөн гөрөөсний ул мөрийг барьж авахад манай киноны баг оролдсон. Энэ аялалын туршид АЭМОУН-ийн Елена Заркова бидний аялалыг зохион байгуулж, асуулга судалгаа авч, орон нутгийн хүмүүстэй танилцуулан, манай кино багийн оролдож буй, найдаж буй зүйлийг бүрэн төгс биелүүлэхийг зорьж байв.

Степной БНГ ба түүний баатрууд

Степной нөөц газрын захирал Анатолий Клюднев бидэнтэй уулзаж, биднийг хээр тал руу аваачсан. Бусад аялалаас хуримтлуулсан бидний туршлагад үндэслэн байгаль хамгаалагчдын байрладаг байнгын сууринд харахыг бид хүсэж байв. Гэсэн хэдий ч хулгайн ангийн эсрэг багийнхан хээр талд цөөн хэдэн өдөр хэнээс хамааралгүй амьдрахад шаардлагатай бүх зүйлсээр тоноглогдсон өөрсдийн “тулааны” машиндаа амьдардаг байна.

Отогийн газрыг хайж байх цөөн хэдэн цагийн дотор бид өвсөн дотор хэвтэж байсан 2 бөхөнгийн янзагыг үргээсэн. Бөхөнгийн зургийн авахын тулд бид үүр цайхаас өмнө бөхөнгийн усанд ордог газрын ойролцоо хоргодох байгууламжийг барьсан. Наймаас илүү цаг үргэлжилсэн эдгээр хүлээлтийн нэгд нь бид артезийн булаг руу цагийн интервалтайгаар ирж буй янзагатай бөхөн гөрөөснүүдийг харсан. Үүний дараа биднийг дахин аялалд дахин дуудах үед бид өвсөн дундаас маш хурднаар агшин зуур гарч ирэх алтан шаргал арьсыг харахын тулд секунд бүрийг хүлээх нь, тэнгэрийн хаяа руу анхааралтайгаар харах үед анир чимээгүй найдварын хамгийн сэтгэл хөдөлгөөн агшин болохыг бид хүлээн зөвшөөрсөн. Чам руу ойртон ирж яваа шар цэгүүдийг харан толгойгоо өргөх үед тэд чиглэлээ өөрчлөн хээр талд дахин сарнин алга болох болно. Чиний камерын өмнө талд гэв гэнэт огт санаандгүй чиглэлээс бөхөн гарч ирэх болно.

Орой бүр бид киноны тухай Анатолий Клюдневийн багийнхантай зөвлөлдөж, бөхөнгийн тухай урт, тийм ч сайхан биш түүхүүдийг сонсож байсан ба бөхөнгийн хувь тавиланг хүмүүс удаан хугацаанд хэцүү бэрхээр сүлжсэнийг ойлгосон. Анатолий Клюднев гайхалтай хүн бөгөөд зөвхөн үүрэг хариуцлагын жагсаалт бүхий захирал хүн биш, нөөц газрын гол ахмад байв. Тэрээр энэ байгаль, газар нутаг, улс орон, тэдгээрийг хамгаалахаар тэмцэж буй хүмүүсийг ихээхэн хүндэтгэн үздэг. Түүний баг анхан шатны мэргэжилтнүүд, нэвтэршгүй хээр талд хулгайн анчдыг мөрдөн өдөр бүр өөрсдийн амьдралаа эрсдэлд оруулж байдаг үнэхээрийн энэрэнгүй үзэлтнээс бүрддэг. Энэхүү өөрийгөө золиослосон, зарим талаар баатарлаг ажилд мөнгө төдийгүй тааламжтай нөхцөл эсвэл төр засгийн дэмжлэг байдаггүй байна.



Зургийг: Амьтан TV суваг

Амьтан TV сувгийн кино хийх байгийнхан Степной нөөц газар, АЭМОУН-ийн ажилтнуудтай

Яагаад эдгээр хүмүүс хээр талд өдөр бүр тэмцлээ үргэлжлүүлж байна вэ? Тэд хэрхэн нөөцөө, санхүүгээ олж байна вэ? Өөрсдийн хувьдаа завших дур хүслээ тэд яаж тэвчиж байна вэ? Би зөвхөн ганц хариулт хэлж чадна: энэ бол мэргэжлийн маш сайн найцсэн баг бөгөөд хамгийн чухал нь үнэхээр хүндлүүштэй, ажил үйлсгээ бие сэтгэлээ зориулсан хүмүүс юм.

Бид хамгаалалттай газар нутагт бөхөн байхад аюулгүй байж чадахыг мэдэж байна. Харамсалтай нь тэд тогтмол нүүдэллэдэг бөгөөд хэн ч алж шархдуулахгүй газарт үлддэггүй. Удалгүй бөхөнүүд Степной нөөц гаурын хилээс гарч яван хулгайн анчдын мотоциклын дуу дуулаж эхлэнэ... гэдэгт бүрэн итгэлтэй байна.

Халимаг ба хээр талын шидтэн

Бид хээрийн лагериас Халимагийн өөр тал нутагт явсан. Энд, Халимагийн Зэрлэг амьтан хамгаалах төвд бид бидний кинонд маш чухал алдагдсан хэсгүүд болох ойроос авсан зураг, бөхөнгийн тунгалаг нүд, инээдтэй хамар, алтан шаргал нуруу зэргийн зургийг авсан. Ялангуяа бидний төлөө тус төвийн албан хаагчид ус хайн өглөө хашаанд ирсэн бөхөнд зориулан хашаанд ус оруулж өгсөн. Байгалийн нөхцөлд бөхөнг анх харсанаас гайхалтай эрс гэс ялгаатай байсан бөгөөд усанд ордог газарт шинэ амьтан ирэх бүрт баярлан, энэхүү үнэ цэнэтэй агшин бүрийг буулгаж авахаар оролдож байснаа гэнэт тэдгээрт ойртон тэдний нүдийг, нууцлагдмал бяцхан толбо бүрийг харж болно.

Тус төвийн захирал Юрий Арылов, Степной нөөц газрын албан хаагчид шиг бөхөнгийн тухай урам зоригтойгоор ярьж байна. Тэрээр шинжлэх ухааны хүн бөгөөд бөхөнгийн тухай түүний өгүүлж буй сонирхолтой баримтыг дурсах үед нь тэмдэглэн авахад хүндрэлтэй байв. Тухайн үед түүний ярьж буй түүхээс Халимагууд урт хугацааны турш бөхөнг хүндэтгэн, энхрийлж ирсэн нь харагдаж байна. Бөхөнг хамгаалдаг, тэдгээрийг халамжлахыг хүмүүст даалгасан хээр талын шидтэн болох Цагаан хөгшин хүн Халимагт цэцэглэж байгаа хууль бус ангийн зөв бурууг ялган шийдэх нь дамжиггүй. Энэ итгэл үнэмшил олон хүний дотор харагдахгүй оршин тогтносоор байна.

Тус төвийн ажилтнууд гэрийн мал асарч байгаатай ялгаагүйгээр бөхөнг халамжилдаг бөгөөд хүний авчирч өгөх өвсийг харан хүүзүүгээ түгшүүртэй сунган зогсох эдгээр эртний гөрөөсийг харах нь гайхалтай байсан. Юрий Арыловын хичээл зүтгэлээр бий болсон энэ популяци нь Европын бөхөнгийн популяцийн эсэн мэнд үлдэх цорын ганц боломж байж мэдэхийг бид улам бүр мэдэрсэн.

Бидний нислэгээс өмнө Елистад өнгөрүүлсэн сүүлийн хэдэн өдөр гэрлийн шонгоос “Би хуучин бөхөнгийн эвэр худалдаж авна” гэсэн зарлалуудыг урж хаяхдаа бөхөн нь үнэхээрийн аюул занал дунд амьдарч байгааг дахин дахин ухамсарлаж байв. Гэртээ өөрөдийн хийсэн киногоо үзэж байхдаа, тектийг бэлдэж байхдаа цаг үргэлж Цагаан хөгшин өвгөний баримлыг сэргээн бодож байв. Би бүхэл бүтэн бөхөнгийн түүхээр дахин аялж хээр талын шидтэн байсаар байгаад, тэрээр амьтаныг хайрлан хамгаалдагт итгэхийг хүсэж байна. Энэ зуур бөхөнг хамгаалахын тулд тэмцэж буй хулгайн анчидтай тэмцэх багийнхан, хууль сахиулах байгуулагынхан төр засгийн нөхцөл сайжирч, илүү хүчирхэг болон өсөх болно. Амьтан телевизийн сувгийнханы бүтээсэн “The Saiga: Elusive Beauty” кино нь бөхөн эсэн мэнд үлдэхэд туслах болно гэдэгт итгэлтэй байна.



Зургийг Алматын ТВ сүлжээ

Зэрлэг амьтан хамгаалах төвд үржүүлж буй бөхөн.

Бидний ажлын тухай дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл: <http://telezoo.tv/>, түүнчлэн манай киноны шинэ ангийг хүлээн вач үзэхийг хүсвэл <http://telezoo.tv/anonsy/item/189-film-saygaki-uskolzayuschaya-krasota> хаягаар хандана уу.

Казахстанд хийгдэж буй ухуулга сурталчилгааны өргөн хүрээтэй ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН КАМПАНИТ АЖИЛ

Гулмира Изимбергенова,
КБТЗХН, gizimbergen@mail.ru

Мэдээллийг нэмэгдүүлэх ажлыг хийж эхэлсэнээр бөхөн хамгааах бидний ажлын амжилтанд ихээхэн ач холбогдолтой болох нь мэдэгдэж байсан бөгөөд эн тэргүүний ажил байсан. Энэ эил бид “Бөхөнг хамгаалъя” нэртэй олон нийтэд зориулсан мэдээлэл өгөх киног Орос, Казах хэлээр бүтээсэн бөгөөд “Бид бөхөнг хамгаалсаар байх болно” нэртэй зурагт хуудас мөн хийсэн. Бид мөн “Бөхөнгийн домог” комик номыг Казах хэл дээр хэвлэхэд тусалсан бөгөөд Устюртын бөхөнгийн популяцийн эх нутаг Актобе бүс нутаг даяар төр захиргааны олон байгууллагууд дэмжлэгтэйгээр зарлалын самбар гаргасан.



Киноны дэлгэцийн зураг.

“Бөхөнг хамгаалъя” киног үзэгчдэд өргөн хүрээтэй мэдээлэл өгөх 1,5 минут үргэлжлэх хэсэг болон ХАА-н яамны Ой ангийн зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн дагуу телевизээр харуулахад зориулсан 30 секунд үргэлжлэх хэсэг гэсэн хоёр хэсэгтэйгээр хийсэн. Одоогоор уг кино нь “Internews Kazakhstan” мэдээллийн агентлагийн бүс нутгийн суваг болон Актобе бүсийн “Рика-ТВ” арилуаны сувгаар цацагдсан байна. 2012 оны 10 сард “Актобе, Казахстан” сувгаар мянган мянган хүн үзэж сонирхсон нь ихээхэн үр дүнтэй ажил болсон. Казахстаны Телевиз Радиогийн компанийн бүс нутгийн удирдлагууд орон нутгийн засаг захиргааны бодлогын тусламжтайгаар эдгээр чөлөөт, олон нийтийн үйлчилгээний нэвтрүүлгийг бэлтгэсэн. Нэмж хэлэхэд OSCE (Organization for Security and Co-operation in Europe)-ийн тусламжтайгаар Астана уг киног бүс нутгийн төвүүд болох бусад хотууд руу илгээсэн (Аарус, Актау, Атырау, Караганда, Шымкент, Павлодар). Мөн үүнийг Шалкар тосгоны 3 дугаар сургуулийн Акбокен экоклуб, Баяганин дүүргийн Оймаут тосгоны “жескийк” клубт үзүүлсэн.

“Бид бөхөнг хамгаалж чадна” зурагт хуудсыг Ой ангийн нийгэмлэгийн хамтын ажиллагааны үр дүнд бүтээсэн. Үүнд үндэсний хууль тогтоомжинд хийгдэж буй сүүлийн үеийн өөрчлөлтийг харуулсан (дээрх мэдээнээс хар). Нэг мянга орчим зурагт хуудас Актобе бүсийн сургууль, орон нутгийн засаг захиргаа, “Охотзоопром” ангийн менежментийн байгууллага, номын сан, зочид буудал, дэлгүүр, олон улсын байгууллага, элчин сайдын яамдад тараагдсан. Ойрын үед Ой ангийн нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр бид Астана, Актобе онгоцны буудал, төмөр замын өртөөн дээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн хүрээтэй мэдээллийн ажил хийнэ гэдэгт итгэлтэй байна.

Ой ангийн нийгэмлэгийн зөвлөснөөр бид “Бөхөнгийн домог” комик номыг казах хэл дээр хэвлэхээр шийдэж зохиогч Макшут Заримбетовой хамтран ажилласан. Энэ хэвлэлийг **NABU**, БХН, КБТЗХН-ийн дэмжлэгтэйгээр хэвлэсэн. Уг комик нь өргөн хүрээтэй тарагдсан бөгөөд ялангуяа хүүхдүүд маш сайн хүлээн авсан. Эдгээр номыг Астанад хүүхэд асрах газарт, хүүхдүүдийн гэрээр, Мөн “Хотын дуу хоолой” буяны концертын үеэр тараасан.

Бид Актобе бүсийн хурдны зам дээр явган зорчигч болон жолооч нарт бөхөн устаж алга болох заналын талаар сануулсан самбарыг байрлуулсан. Үүнийг хийхэд тусалсан олон төрийн байгууллагад, тухайлбал Актобе зэрлэг амвтан хамгаалах газар, Хүрээлэн буй орчин, Байгалийн нөөцийн хэлтэс, түүнчлэн Актобе бүсийн удирдлагад талархах ёстой.



Хүүхдүүд “Бөхөнгийн домог” комикийг уншиж байна.

“Устюртын ландшафтыг хамгаалах санаачлага” төслөөс гарч буй эдгээр зүйлүүд нь энд хүрээд зогсоогүй болно. Бидний ирээдүйн төлөвлөгөөнд сэтгүүлчдэд болон телевиз, радиогийн хөтөлбөрт ярилцлага өгөх, сургууль болон их сургуультай ажиллах, түүнчлэн бөхөн хамгааллын тухай мэдээллээр олон нийтийг хангахад оршино.

Устюртын ландшафтыг хамгаалах санаачлага төсөл нь АНУ-ын Хөгжлийн хөтөлбөрийн **USAID / Sustainable Conservation Approaches of Priority EcoSystems (SCAPES)** program, the Их Британий Дарвины Санаачлага болон Диснейн дэлхий дахиныг хамгаалах сангаас санхүүждэг байна.

Устюртын ландшафтыг хамгаалах санаачлага төслийн хийсэн зурагт хуудас

Бөхөн том үзүүлэн болж байна

Елена Быкова, esipov@xnet.uz, Севера Шаропова, sevara.sharapova@undp.org

Сүүлийн хэдэн арваны турш дэлхийн бөхөнгийн популяци 95 хувиар буурч, аюулын өндөр зэрэглэлд хүрсэн билээ. Узбекистаны зөвхөн Устюртын өндөрлөгт жил бүрийн өвөл бөхөн ирдэг. Узбекистаны БНУ-ын улаан номонд бөхөн ховор зүйлийн жагсаалтанд албан ёсоор орсон. Үүнээс эхлэн хамгааллын үйл ажиллагаа хэрэгжиж эхлэсэн. Үүний нэг нь бөхөнгийн тухай олон нийтийн мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор “Хээр талын домог” нэртэй бөхөнгийн янзаганы тухай өгүүлсэн хөдөлгөөнт киног бүтээсэн явдал билээ. Уг кинонд сүргийн ард хоцорсон бөхөнгийн янзага хулгайн анчдын хялбар зууш болдог тухай өрөвдөлтэй түүхийг өгүүлдэг. “Хээр талын домог” киног Гала кино студи Бөхөн хамгаалах нийгэмлэгийн захиалгаар Пенгвин клуб, Дисней Канада, UNDP-GEF болон Узбекистаны БНУ-ын Байгаль хамгаалах төрийн зөвлөлийн дэмжлэгтэйгээр бүтээсэн.

Хөдөлгөөнт киног илүү их дурсгалтай хийхийн тулд бид



Сергели дүүргийн “Баркамол Авлод”-ын хүүхэд, багш нар хүүхэддэйн кинонд зориулан зурсан зургийн хамт

Хүүхдүүд өөрсдөө үүнийг бүтээх ажилд оролцох ёстой бөгөөд кино нь хөдөлгөөнт дүрс ба хүүхдүүдийн тоглоом гэсэн хоёр хэсгээс бүтэх ёстой гэж шийдсэн. Хөдөлгөөнт дүрсэд “Янги Авлод Форуми” болон “Баркамол Авлод” төв, Хүүхдийн хөгжим урлагийн сургууль, Устюртын 15, 54 дүгээр сургуулийн хүүхдүүдийн зургийг ашигласан.



Бөхөнгийн тархац нутагт орших Устюртийн өндөрлөгийн Кырк-кыз тосгоны хүүхдүүд кинонд тоглосон. "Хөдөлгөөнт дүрснүүд нь зарим талаар маш өвөрмөц, жинхэнэ, туйлын хэцүү байсан" хэмээн зохиолч Евгения Палекова хэлсэн. "Үндсэн санаа нь хүүхдүүдийн зургийг холиход байсан. Хүүхэд бүр түүхийн тодорхой хэсгийг зурсан юм шиг санагдсан. Хүүхдүүд зөвхөн зурах төдийгүй янз бүрийн аргаар бодож сэтгэдэг болохыг та мэднэ".

Узбекистанд хэрэгжиж буй утга зохиол, урлагийн экологийн боловсрол олгох шинэ төсөл

Елена Быкова, esipov@xnet.uz

Өнөөдөр бүх хүн төрөлхтөний анхаарал бөхөнгийн хувь тавиланд хандаж байна. Дэлхийн хамгийн эртний хөхтөн амьтны нэг болох устаж алга болохын ирмэгт байна. Эдгээр хээр талын гөрөөсний ер бусын түүхүүд, тэдний өнөөгийн эмгэнэлт хувь тавилан, эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнгийн талаарх экологичдын тооцоо, Узбекистан төдийгүй дэлхий дахинд бөхөн хамгаалах талаар хийгдэж байгаа ажил, эрдэм шинжилгээний өгүүлэл, баримтат кино, хувь хүний ажиглалт зэрэгт тулгуурлан зохиолч Райм Фаркади "Улаан номноос бөхөнгийн янзага" нэртэй бөхөнгийн янзаганы адал явдлын талаар өгүүлсэн ном бичихээр зориг шулууджээ. Зохиолч, сэтгүүлч Ахмад Ходжа энэ номыг Узбек хэл рүү орчуулан гаргажээ. Янги Авлод Форум студийн зураач, багш Карине Кургина ер бусын, маш дулаан зургаар чимэглэжээ.



Карине Кургина болон түүний шавь нар бөхөнгийн номтой цуг

Үзэгдэд өргөн хүрээтэй хүргэх зорилгоор киног Укбек, орос, англи гэсэн 3 хэл дээр хийсэн. Ташкентын сургууль болон Ташкентийн олон улсын сургуулиас ирсэн хүүхдүүд дуу бичүүлэхэд оролцсон. Хүүхдүүд асар их ажил хийхийн сацуу бөхөнгийн талаар суралцсан. Охидын нэг болох Мая Лайтинен уг төсөлд оролцоход маш сонирхолтой байсан ба энэхүү хүүхэддэйн кино нь бөхөн хамгаалалт нөлөөлөлх болно гэдэгт тэд итгэлтэй байсан талаар хэлсэн.

Үзэгчийн хувиар киног үнэлэхэд бидний бодсон шиг уг кино нь маш нэгдмэл, дулахан түүх, сэтгэл хөдөлгөсөн өрнөл, аз жаргалтай төгсгөлтэй байсан. Энэ нь хүүхдүүдийн зүрхний дулаан илч, тэдний итгэл бөхөнгийн бяцхан янзагыг хамгаалах болно гэдгийг харуулж байна.

3 сарын 15 нд "Хээр талын домог" хүүхэддэйн кино Ташкент хотноо нээлтээ хийсэн.

Дэлгэрэнгүй мэдээллийг авахыг хүсвэл

<http://www.un.uz/ru/news/208.html>, <http://kultura.uz/home/29-news/3872-prezmult.html> хаягт хандана уу.

Хүүхэддэйн

киног

www.youtube.com/user/SaigaConservation сайтаас татаж авч болно. Та 3 хэлд дээрх DVD-г Елена Быкова, Севера Шарпова эсвэл Галина Винаградова нараас gala.film.v@gmail.com авч болно.



"Янги Авлод" студи Карине Кургинагийн бөхөнгийн талаарх хүүхдийн номонд зурагнууд.

Энэхүү олон улсын утга зохиолын, урлагийн экологийн төсөл нь Бөхөн хамгаалах нийгэмлэг, хүүхдийн эко сэтгүүл "Родничник", Ташкентийн хүүхдийн урлагийн студи, экологи, соёл, эрүүл амьдралын хэв маягийн "БАКСТКЕЛ" төрийн бус байгууллагын оролцоотойгоор хэрэгжсэн. Үүнийг Пенгвин клуб, Дисней Канада нар санхүүжүүлсэн. Райм Фаркади залуу хамгаалагчнар, багш нарт энэхүү зохиолыг уншсаны дараа байгаль хамгаалах үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байгаа манай авъяаслаш хүүхдүүдийн хүч чадлыг тэрээр ойлгосон. Уг ном Орос болон Узбек хэл дээр хэвлэгдсэн. Нэмэлт мэдээлэл болон номын үнэгүй хувийг авахыг хүсвэл Елена Быковатай холбоо барина уу.

Монгол, Хятадад бөхөнгийн эд эрхтний хил дамнасан худалдааг хязгаарлах нь

Б.Батхуяг,Б. Чимэддорж, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар,chimeddorji@wwf.mn

Бөхөнг хууль бусаар агнах болон эврийн хууль бус худалдаа Монголд байсаар байна. Сүүлийн үеийн судалгаагаар Хятад дахт бөхөнгийн эврийн хэрэглээ 9000 орчим кг бөгөөд бөхөнгийн эвийн эрэлт өндөр орны тоонд орж байна (TRAFFIC тайлан, 2010). Энэхүү хэрэглээг Казахстанас Монголоор дамжуулан бөхөнгийн эврийг ре-экспорт хийх замаар, мөн Монгол бөхөнгийн эврийг Хятад руу хулгайгаар хил гаргах замаар хангадаг байсан. Хилийн боомт дахь хил хамгаалах алба, гаалийн ажилтнууд, мэргэжлийн хяналтын байцаагч нар хилийн ойролцоох нутагт ажиллаж буй байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч нар, цагдаагийнхантай нягт хамтран ажиллаж зэрлэг амьтдын хууль бус худалдааг хянахад чухал үүрэгтэй оролцдог. Иймээс ДБХС-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар Монгол, Хятадын хил дамнасан бус нутагт бөхөнгийн эврийн худалдаанд хяналт тавихын тулд олон улсын зохицуулгын механизмыг бий болгох төслийг санаачилан хэрэгжүүлсэн. 2011 оны 11 сараас 2012 оны 11 сар хүртэлх хугацаанд хэрэгжсэн уг төслийн томоохон санхүүгийн дэмжлэгийг Бөхөн хамгаалах нийгэмлэгээр дамжуулан АНУ-ын зэрлэг амьтан, загас судлалын холбооноос өгсөн. Уг төсөл нь харилцан ойлголцлын санамж бичигт олон улсын зохицуулгын механизмыг бий болгох, хил дамнасан хамтын ажиллагаанд ЗАУХЗХК-ийн хэрэгжилт, хууль бус бус худалдааны эсрэг арга барил, бөхөнгийн бүтээгдэхүүнийг таних зэрэг чухал асуудлуудад хаягласнаар бөхөнг хамгаалахын тулд ЗАНЗК-ийн Олон улсын дунд хугацааны ажлын хөтөлбөрийн заалтуудыг хэрэгжүүлэхэд чухал холбогдолтой.

Төслийн зорилгууд:

- Төрийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлснээр зэрлэг амьтдын худалдаанд Хятад Монголын харилцаан холбоог бий болгох;
- Бөхөнгийн эд эрхтний хууль бус худалдааг үр дүнтэй хянахын тулд эн тэргүүнд хилийн боомтын ажилтнууд, гаалийн байцаагч нарын чадавхийг дээшлүүлэх;

- Бөхөн, түүний эд эрхтний худалдаанд төвлөрсөн олон улсын болон үндэсний хууль эрх зүйн орчингийн мэдлэгийн талаарх олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх.

Төсөл хэрэгжиж эхэлснээр хүрсэн томоохон үр дүн нь:

1) Монгол улсын Байгаль орчин, Ногоон хөгжлийн яам, Хятад улсын Хүрээлэн буй орчны яамны хоорондох харилцан ойлголцлын санамж бичигт засгийн газрын хамтарсан уулзалтаар 2012 оны 12 сард эцэслэн боловсруулсан. Хоёр яамны хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг нь зөвхөн бөхөнг нцгойлон үзээгүй бөгөөд экологийн, биологийн төрөл зүйлийн хамгаалал, хил дамнасан хүрээлэн буй орчны хамтын ажиллагаа зэрэг хоёр улсын хамтын ажиллагааг тусгасан. Уг төслийг оролцогч талууд хоёулаа санхүүгийн болон техник хэрэгслээр идэвхтэй дэмжсэн. Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Хятад улсын ЗАУХЗХК-ийн менежмент хариуцсан байгууллага сургалтанд оролцогчдын тоо өссөнөөс үүдсэн, инфляцаас үүдсэн нэмэлт зардлыг шингээн ихэнх үйл ажиллагааны зардлыг даасан.

2) Хятадын Бээжинд болсон хамтарсан уулзалтаас гарсан шийдвэрт үндэслэн (2012 оны 3 сарын 28-29, Бээжин) Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Хятад улсын ЗАУХЗХК-ийн менежмент хариуцсан байгууллага хамтран 2012 оны 11 сарын 6-9-ны хугацаанд Хятадын Өрөмчи хотод сургалт зохион байгуулсан. 50 гаруй хууль сахиулах ажилтнууд оролцсон бөгөөд сургалтын амжилтыг дараагийн 12 сард илрүүлсэн хууль бус үйл ажиллагааны тоотой харьцуулан хянах болно. Оролцогчид өөрсдийн чадавхийг нэмэгдүүлэх боломжтойг, зэрлэг амьтны хэргийг шүүх үйл ажиллагааг оролцуулан тэдгээртэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэхтэй холбоотой сургалтын материалыг хүлээн авсан. Боломжит санхүүжилт, тэдгээрийн тус тусын нөөц бололцооноос хамааран тэд хамтран ажиллах,

中蒙野生动物贸易控制联合培训班 Sion-Mongolia Joint Training Seminar on Wildlife Trade Control

2012.11.7



Зургийг Хятадын ЗАУХЗХК-ийн менежмент хариуцсан хэлтэс

Монгол, Хятадын бөхөнгийн тархац нутагт байх хилийн шалган нэвтрүүлэх 3 цэгийг чадваржуулах сургалтанд оролцогсод Хятадын Өрөмчи хотноо

Сургалт болон чадавхижуулах үйл ажиллагааг зохион байгуулах, өөрсдийн өдөр тутмын ажилд хил цэргийн болон хамтын ажиллагааны хэм хэмжээг өсгөх зэрэг үйл ажиллагааг зөвшөөрсөн. Хууль хэрэгжүүлэх байгууллагын сургалт нь зөвхөн уг сургалтыг хүлээн авах ажилтнуудын чадварыг нэмэгдүүлээд зогсохгүй, хилийн шалган нэвтрүүлэх цэг, олон нийтийн худалдааны газарт агентлаг хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой.

3) Төслийн баг судалгааны хандлага, мэдээлэлд тулгуурлан олон нийтийн дунд мэдээллийн цоорхойг нөхөх зорилгоор хоёр хэл дээр материал боловсруулсан (зурагт хуудас, товхимол). Олон улсын болон үндэсний хууль эрхзүйн хүрээнд бөхөн хамгааллын хүрээнд хэрэгжих байдал, бөхөн болон түүний эд эрхтний хууль бус худалдаанд оролцсон хүнд ноогдуулах хуулийн хэрэгжилтийн тухай мэдээллийг оруулсан. Зурагт хуудас нь хууль бус үйл ажиллагааны талаар мэдсэн хүмүүст холбоо барих хаягийг мөн харуулсан (Диаграмм.1). Энэхүү зурагт үзүүлэн Бөхөн тархац нутагт амьдарч буй хүмүүст болон Монгол, Хятадын хил дээрх хилийн шалган нэвтрүүлэх 3 үндсэн цэгт тараагдсан.

Уг төслийн багийнхан уг төслийг санхүүжүүлсэн Нэгдсэн улсын Зэрлэг амьтан, загас судлалын холбоо, үүнийг удирдан зохион байгуулсан Бөхөн хамгаалах нийгэмлэгийн хамт олонд чин сэтгэлээсээ талархаж байна. Бид хамтарсан хурал, сургалт болон зохион байгуулалтын дэмжлэг үзүүлсэн Монголын ЗАУХЗХК-ийн менежментийн хариуцсан ноён Дончинбуугийн Энхбат, Доржгүрэмийн Батболд нарт болон Хятадын ЗАУХЗХК-ийн менежментийн хариуцсанноён Менг Хианлин, Лу Хиаопинг нарт мөн талархлаа илэрхийлье.



Зураг 1. Зэрлэг амьтдын хууль бус худалдааны талаарх зурагт хуудас

Бид идэвхтэй оролцоо, мэдээлэл солилцсон болон хил дамнасан бүс нутгийн зэрлэг ан амьтны хууль бус худалдаатай тэмцэх ирээдүйн ажилд ач холбогдол бүхий тодруулга, санал зөвлөмжийг өгсөн хууль сахиулах байгууллага, яамдын хэлтэс, нийгэмлэгт гүнээ талархаж байна.

Хэвлэлийн мэдээ

Волго-Уралын бөхөнгийн популяцийг хамгаалах хэлэлцээрт Орос Казахстан улс гарын үсэг зурлаа.

ОХУ-ын байгалийн нөөц, экологийн сайд Сергей Донской, Казахстаны БНУ-ын ХАА-ийн сайд Асылджан Мамытбеков нар Волго Уралын бөхөнгийн популяцийг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглах яам хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурлаа. Уг баримтанд Павлодор хотноо (Казахстан) 2012 оны 9 сарын 19-нд Орос Казахстаны бүс нутгийн хамтын ажиллагааны 9 дэхь форумын үеэр гарын үсэг зурсан. Уг хэлэлцээр эхний ээлжинд 5 жилийн хугацаатай хэрэгжих бөгөөд

Хэрвээ хугацаа дууссан бол хоёр тал хүсвэл цаашид дахин таван жилээр сунгах боломжтойгоор байгуулсан. Энэ хэлэлцээр ёсоор тодорхой бүс нутагт нүүдэллэн ирж бөхөнгийн тоо толгойг үнэлэх хамтарсан судалгааны ажил, тэдгээрийн нүүдлийн замын урт, чиглэлийг тодорхойлох, популяцийн тооллогын арга зүйг сайжруулах, хилийн районд тэдгээрийн нүүдэл шилжилтийн мөрдөх зэрэг үйл ажиллагааг хангана. Энэхүү судалгааг хамгааллын арга хэмжээг практикт хэрэгжүүлэх зорилгоор гүйцэтгэх болно. Талууд байгаль хамгаалах хуулийн зөрчилтэй тэмцэх зорилгоор хууль тогтоомжийг сайжруулахад чиглэсэн зөвлөмжийг боловсруулах болно.

Дэлгэрэнгүйг доорхи хаягаар үзнэ үү:
<http://www.priroda.ru/news/detail.php?ID=106746a>
<http://sa.vesteppe.org/ru/archives/9560>.

Зургийн ГЕО сангуул



Халимагт бөхөн агнахыг хорив.

Бөхөнг арижааны болон спорт агнуурын зорилгоор агнах явдлыг 2020 оны 12 сарын 31 хүртэлх хугацаанд хорьлоо. Мөн бөхөнгийн эврийг цуглуулах, бэлдэх, худалдан авах эсвэл худалдах зэрэг бөхөнгийн гаралтай бүтээгдэхүүний худалдааг хориглосон. Оросын IFAW's-ийн төлөөлөгчийн тооцоолсоноор сүүлийн 10 жилийн туршид Халимагийн бөхөнгийн тоо толгой 90 гаруй хувиар буурсан байна. Европын бөхөнгийн тоо толгойн энэхүү бууралт нь эр амьтныг сорчлон ашигласнаас популяцийн нөхөн үржихүй буурсаны улмаас тэдгээрийн нөхөн сэргэлтийн хэмжээ буурахад хүргэсэн байна.

Дэлгэрэнгүйг доорхи хаягаар үзнэ үү:
http://www.elista.org/index.php?option=com_content&view=article&id=16761:2013-02-19-07-33-54&catid=1



Зургийг Аманан ТВ сүваг

НҮБХХ/ДДБХС Оросын бөхөнг хамгаалахаар ажиллаж байна.

НҮБХХ (UNDP) 2013 онд Оросын ТХГН-ийн сүлжээг өргөжүүлэх оролцохоор шийдсэн. Ялангуяа Астраханаас Яшкул, Яшкулаас Комсомолск, Комсомолскоос Улаан Хөл хүртэлх авто замаар хязгаарлагдсан газар нутагт Халимагийн бөхөн хамгаалахын тулд бүс нутгийн дархан газрыг үүсгэн байгуулах төлөвлөгөөтэй байна. Бүс нутгийн засаг захиргааны хэвлэлийн төлөөлөгч энэ нутаг нь 7000 гаруй бодгалиар хэмжигдэж буй өнөөгийн пре-Каспийн бөхөнгийн популяцийн 95 орчим хувийг хамрах болно хэмээн цохон тэмдэглэсэн. Бүс нутгийн засаг захиргаа Халимаг болон Астраханы бүс нутагт Бөхөн хамгаалах тусгай багийг дор хаяж 30 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулахаар төлөвлөж байна. Үүнийг төрөөс санхүүжүүлэх болно. ОХУ-ын НҮБХХ-ийн хээрийн төслийн дарга Евгений Кузнецов хэлэхдээ: "Төр засгаас өөр хэн ч, байгуулага, санхүүжүүлэгч нар тусалж чадахгүй. Хэрвээ бид одоо юу ч хийхгүй бол бөхөн гөрөөс 5 жилийн дотор устаж үгүй болно. Төрийн бодлого зайлшгүй хэрэгтэй бөгөөд эсрэгээр бид уг зүйлийг устан алга болохыг харж шившигтэй байдалд орно. Бидэнд зөвхөн Казахстанас Астрахан, Волгоградын бүсэд нүүдэллэн ирэх эдгээр бөхөнгүүд байх болно" гэжээ.

Дэлгэрэнгүйг доорхи хаягаар үзнэ үү:
<http://ria.ru/eco/20130115/918201332.html> болон
<http://ria.ru/eco/20130111/917751624.html> болон
http://www.elista.org/index.php?option=com_content&view=article&id=17076:2013-03-19-08-42-27&catid=1.



Зургийг Аманан ТВ сүваг



Зургийг Казахстаны БНУ-ын ХАА-н яам

Казахстаны шинээр байгуулагдсан байгалийн нөөц газар хоёрдахь Серенгети болохоо амлав.

Казахстаны БНУ-ын ХАА-н яамны Ой, ангийн менежментийн зөвлөл Алтын Дала нэртэй тус улсын 27 дахь байгалийн нөөц газрыг үүсгэн байгуулав. Нийт 489766 га талбайг хамарсан уг газар нь Казахстаны төв хэсгийн хээрийн болон цөлийн экосистемийн биологийн төрөл зүйлийг хамгаалахад чиглэгдсэн. Костанай бүс нутгийн Зангелди, Амангелди дүүргийн нутагт уг нөөц газар оршино. Энд Бетпакдалагийн бөхөнгийн популяцийн үндсэн амвдрах орчин бөгөөд нүүдэллэн ирдэг, төллөдөг газар юм. Тус нутгийн ургамлын зүйлийн бүрдэл болох 370 орчим зүйлийн 23 нь ховор байдаг байна. Сээр нуруутан амьтны аймагт 57 хөхтөн, 275 шувуу, 11 мөлхөгч, 4 хоёр нутагтан, 9 зүйл загас байна. Хоёр зүйлийн ховор нуруутан амьтдыг тахь адуу болон онагер (хулан адуу) –ийг нөхөн сэргээх хөтөлбөр хэрэгжсэн.

Дэлгэрэнгүйг доорхи хаягаар үзнэ үү:
<http://kt.kz/?lang=rus&uin=1133168071&chapter=1153564826> болон
<http://www.centrasia.ru/newsA.php?st=1351851360>.

ӨГҮҮЛЭЛ

Устюртын бөхөнгийн популяцийг хамгаалах судлахад сансрын дохиолол дамжуулагчийг ашиглах нь

Алберт Салемгареев

КБТЗХН, albert.salemgareev@acbk.kz

Устюртын ландшафтийг хамгаалах төслийн нэг хэсэг болгон 2012 оны намар КБТЗХН-ийн судлаачид Устюртын бөхөнгийн популяциас дахин 5 бөхөнд сансрын дохиолол бүхий хүзүүвч зүүсэн. Өнөөгийн байдлаар уг популяцид идэвхтэй дохио өгч буй 9 хүзүүвчтэй амьтан байна.

Устюртын бөхөнгийн популяци нь Казахстаны хамгийн жижиг популяци бөгөөд өнөөгийн байдлаар 6500 бодгальтай хэмээн үнэлэгдсэн (агаарын тооллогод үндэслэсэн, БМ-15-аас хар). Энэхүү популяци нь хил дамнан Узбекистаны Устюртын тэгш өндөрлөгийн Каракалпакийн хэсэгт мөн тохиолдох бөгөөд Казахстанас өвлийн улиралд уг нутаг руу нүүдэллэн ордог. Урт хугацааны улирлын нүүдэл шилжилт бөхөнд нийтлэг зүйл бөгөөд тэдгээрийн зай цаг агаарын нөхцлөөс хамаардаг. Өнөөг хүртэл энэхүү нүүдлийн замын уртыг тодорхойлсон бодитой мэдээлэл байхгүй байна.


УЛХТөсөл нь КБТЗХН-ийн дэмжлэгтэйгээр 2011 оны 9 сараас сансрын дохиолол бүхий хүзүүвч бөхөнд зүүх ажлыг эхлэсэн. Бид одоогоор 10 GPS+ хүзүүвч (*Vectronic-Aerospace*) зүүсэн байна. Энэ хжлын үндсэн зорилго нь өвөлжих болон төллөх газар, Устюртын бөхөнгийн популяцийн нүүдлийн зам, бусад биологийн замыг тодорхойлох, түүнчлэн амьтны байршлыг сансрын дохиолол ашиглан тодорхойлсноор хамгааллын үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд оршино. 3-4 наснаас доошхи эмэгчинд амьтанд хүзүүвч зүүсэн бөгөөд эмэгчин амьтны мэнд үлдэх чадвар орооны үед ихэвчлэн үхдэг эрэгчнийхээс илүү байсан. Эрэгчин амьтан нь орооны үедээ огт өвс иддэггүй бөгөөд үүнээс болж сульданд махчид болоод хулгайн анчдын хувьд хялбар олз болдог.



Зургийг Алберт Салемгареев

Сансрын дохиолол бүхий хүзүүвчтэй эм бөхөн.

10 эмэгчинд хүзүүвч зүүснээс 6 амьтны дохиолол 1-5 долоо хоногийн дараа дохио дамжуулахаа больсон бөгөөд харин үлдсэн 4 амьтны хувьд жилийн турш байршлын мэдээлэл өгч байсан. 2011 оны 10 сараас 2012 оны 10 сар хүртэлх хугацаанд нийт 4,152 байршлын мэдээлэл хүлээн авсан бөгөөд өдөрт 3 цэг өгсөн байна. 3 хүзүүвчнээс хүлээн авсан нийт байршлын мэдээллийн 97 хувь нь амжилттай өгөгдсөн бол 4 дэхт хүзүүвчнийх 86 хувьтай байна. Телеметрийн мэдээллийг газарзүйн мэдээллийн систем ArcGIS-т хөрвүүлсэн ба бөхөнгийн тархацын зургийг өвөл зуны байршил нутаг, төллөх болон ороо хөөцөөнний үеийн байршлын мэдээллийг ашиглан зурагласан. (Зураг 1).




Зураг 1.

Минимум конвекс полигонд үндэслэн гаргасан бөхөнгийн жилийн болон улирлын байршил нутаг


Зуны байршил нутаг 5 сарын сүүлчээс 9 сарын сүүлч хүртэл байршилд, өвлийн байршил нутаг 12 сарын эхнээс 3 сарын сүүлч хүртэлх хугацаанд авагдсан цэгэн мэдээлэлд үндэслэн зурагласан. Төллөдөг газрын зураглалыг 5 сарын эхнээс сүүлч хүртэлх хугацааны мэдээллийг ашигласан бол ороо хөөцөөны үеийн тахцын зураглалыг 12 сарын 5-наас 12 сарын дунд хүртэлх хугацаанд авагдсан цэгэн мэдээлэлд үндэслэсэн. Ороо хөөцөөний болон төллөх үеийн байршил нутаг нь магадлах газрын судалгаа хийлгүйгээр зөвхөн телеметрийн мэдээлэлд үндэслэн тогтоогдсон болохыг тэмдэглэн хэлэхийг хүсэж байна. Газрын зурагт харуулсанчлан (Диаг. 1), өвлийн байршил нутаг нь нимгэн цасан бүрхэвчтэй Устюртын тэгш өндөрлөгийн хойд хэсэгт байдаг бол (Казахстаны нутаг: Матайкум ын элс, Асматайматайн давсан тогоо) байна. Бөхөнгүүд мөн Каракалпакын хойд хэсэг рүү нүүдэллэн ордог байна (Узбекистан, Казах-Узбекийн хилээс 35 орчим км зайд). Бөхөнгүүд 3 сарын ихэнх хугацаанд Узбекистанд байршиж байв. Өвөлжих газар нутгийн хэмжээ 1500 км² хүрнэ. Зуны улиралд бөхөнгүүд тогтмол усан хангамж бүхий Шагырай тэгш талын Шошкакол уулын хөндийд байдагийг тогтоосон. Зуны байршил нутгийн хэмжээ 4500 км² болно. Бид бөхөнгийн тархцын зураг болон тэдгээрийн байршилд ихээхэн ач холбогдол бүхий газар нутгийг бүрэн гүйцэд зураглан гаргах зорилгоор газрын мониторинг судалгаатай хослуулан илүү их телеметрийн мэдээлэл цуглуулах хэрэгтэй.

2011-12 оны өвөл бид Узбекистан хил хязгаарт орсон байршил нутгийг тогтоохыг зорьсон (Зураг. 2). Бөхөнгийн шижлит хөдөлгөөний зураглалын нэгийг үзвэл амьтан нь хилийн заагийг хөндлөн гардаггүй бөгөөд, хэрвээ өөр газар нутаг руу нүүдэллэж байгаа бол хөндлөн огтлон гардаг байна. Хоёрдахь жишээнд хилийн тор даган гарах гарцыг хайн 14 км нүүдэллэсэн байх ба (Зураг 3) эцэст нь амжилттай огтлон гарсан байна.

Миний бие Устюртын популяци нь дэхийн хамгийн жижиг популяци болохыг нотлохыг хүсэж байна. Хилийн бат бэх торон хашаа нь амьтан ихээр үхэж хорогдож болох хатуу ширүүн, цас ихтэй өвөл нүүдэллэн шилжихэд саад тоггор учруулсанаас үүдэн бөхөнгийн тоо толгойг хорогдуулахад нөлөөлөх болно. Устюртын бөхөнгийн популяцийн сансрын дохиолол бүхий мониторинг Казахстаны бусад бөхөнгийн популяцид хийгдэж байгаа шиг (Бетпақдала, Урал) үргэлжлэн хийгдэж байна.



Зураг 2. Ажиглалтын хугацаанд хийсэн бөхөнгийн нүүдэл



Зураг 3. Хүзүүвчтэй хоёр бөхөнгийн улирлын шилжилт хөдөлгөөнд Казахстан, Узбекистаны хоорондох хилийн торон хашааны нөлөө.

Казахстаны баруун хэсгийн бөхөнгийн үхлийн бодит шалтгаанд хийсэн зайнаас тандах болон *in situ* анализ

Антоний Дансер; Викториа Пинион; Ричард Кок; Орынбаев Мукит; Мария Каристеттер; Навиндер Сингх; Сара Робинсон; Бибигул Сарсенова; Е.Ж.Милнер-Гулланд

Зөвлөх редактор: Антоний Дансер, anthony.dancer09@imperial.ac.uk

Оришил

Бөхөн гөрөөсний ихээр үхсэн тохиолдол Казахстаны баруун хэсэгт Борсид Уралын популяцид төллөлтийн өмнө хугацаанд 2010 болон 2011 онд ажиглагдсан. Халдварт өвчин үүсгэгчээр үхэхийн оронд энэхүү үхэл хорогдол бэлчээртэй холбоотой болох нь нотлогдсоноор (бусад газарт буй нэг ижил популяцийн халдваргүй амьтдын 75 хувь үхсэн; бие гүйцсэн амьтад хурц хэлбэрийн амьсгалын боогдолт, батралаас шалтгаалн гэнэт үхсэн) илжил төрлийн өвчин эмгэг, шинж тэмдэг тухайн хоёр жилд тэмдэглэгджээ (дэлгэрэнгүйг БМ 14-ээс хар). Үүнд үндэслэн өнөөгийн таамаглал нь төллөлтийн өмнөх бэлчээр нь ер бусын шим тэжээлээр баялаг, хурдан ургадаг, чийгийн агууламж ихтэй, нийтлэг буй ургамлын зүйлийн хэрэглээнээс үүдсэн байна. Үхлийн ер бусын байгаль цаг уурын нөхцөл, (шим тэжээллэг, чийг ихтэй хонхор гадаргуу), хэвийн бус дулаан/ эсвэл чийглэг уур амьсгал, эсвэл бэлчээрийн нөхцөл зэрэг эдгээр онцлогийг харгалзан үзсэн. Энэ ургамлын хэрэглээ нь **Atypical Interstitial Pneumonia (AIP)**, эсвэл нүцгэн газраас гэнэт сахлаг өвстэй газарт ирсэн үхэр шиг мэдрэлийн цочролд хүргэдэг байна. Бид энэхүү таамаглалын урьдчилсан нөхцлийг нэгд: цаг уурын нөхцөл болон үхэл болсно болсон ургамалжилтын өвөрмөц шинжийг зайнаас дандан судлалын зурагнаас илрүүлэх, хоёрт: бэлчээрийн хэрэглээ болон шим бодисын чанарыг тодорхойлох *in situ* мэдээлэл цуглуулах аргаар шалгасан.

Арга зүй


Бид урт хугацааны вариацийн цуваанаас чухал ач холбогдолтой байж болох уг явдал болохын өмнөх температурыг олохын тулд онлайн цаг уурын мэдээ, мөн ургамлын бүтээмж, чийгийн агууламжийн урт хугацааны вариациас үхэл болсон бүс нутгийн болон хөрш зэргэлдээх бүс нутгийнхийг авахад сансрын зураг тус тус ашигласан.

Бид Оросын Александров-Гай, Казахстаны Фурманово болон Уралск (80, 155, 300 зайд орших) гэсэн цаг уурын 3 станцын мэдээнээс 30 жилийн температурын дундажийг бүс нутгийн 2010 болон 2011 оны цаг уурын нөхцөлтэй харьцуулан үзсэн. Харамсалтай нь бидэнд хангалттай хэмжээний хур тунадасны мэдээлэл байгаагүй. Бид ургамлын бүтээмжийн индексийг гаргах (NDVI) болон хөрсний чийгшил болон усны агнууламжийг тогтооход (NDWI) 2000-с дээш 16 өнрийн давдамжтай 250 м-ийн нарийвчлалтай MODIS хиймэл дагуулын зургийг ашигласан.


In situ ажиглалтыг хийхдээ үхэл болсно бүс нутгийн ургамлын бүлгэмдлийн бүтэц, зүйлийн баялагийг 2011 онд бөхөнд нөлөөлөөгүй, мөн 2010 онд бага зэрэг нөлөө үзүүлсэн байж болох хөрш зэргэлдээх төллөдөг нутгийнхтай харьцуулсан бол, хонхор газрын ургамлын зүйлийн баялагийг мөн тэгш тал газрын болон өндөршилтэй харьцуулан үзсэн. Бид мөн AIP бий болоход чухал нөлөөтэй L-тритопан ургамалд байгаа эсэхийг шалгасан. Бид 2012 оны 5 сард топографийн хэв шинжид зохицуулан E-W трансектын дагуу квадратад суурилсан ургамалжилтын судалгааг хийсэн. Бүлгэмдлийн түвшингийн ялгааг зүйлийн хуримтлалын муруйг ашиглан тодорхойлсон баялаг, ординацийг ашиглан тооцоолсон. Тогтмол идээшилдэг болон харьцангуй элбэгшил бүхий зүйлүүдээс авсан дэжинд өндөр үзүүлэлт бүхий хромотаграфийн аргыг ашиглан L-тритопаны агууламжийг шалгасан.

Үр дүн

Цаг уурын бүх станцаас авсан температурын бичлэг ижил байдалтай байна. Тухайн 2 тохиолдолд хүйтэн өвөл болсон бөгөөд (Диаграмм 1): Александров-Гай дахь өдрийн хамгийн их температурын дундаж нь 2010 оны 1 сарын сүүлээр -17.3°C , жилийн хугацааны дундаж 12°C -аас доош байвал 2011 оны 2 сарын сүүлээр -16.3°C харьцангуй доогуур байсан ба дунджаар 13°C байсан. Ялангуяа 2010 онд ажиглагдсан хэвийн бус бэлчээрийн ургацыг нэмэгдүүлэхэд нөлөөлж болох таамаглаж буй хүчин зүйл хаврын улиралд дахь дулаан температур нь 2010 онд ажиглагдсан бол 2011 онд ажиглагдаагүй. 2010 он: 2010 оны 5 сарын эхээр 27.0°C байсан бол дундаж нь 6°C -аас дээш байсан.



Диаграмм 1. ОХУ, Александров-Гай дахь арав хоног тутмын хамгийн их температурын дундаж (үхэл болсон газраас 80 км зайтай).



Зураг 2. Үхэл болсон хугацаан дахь ойролцоох газар нутгийн 50x50 км хэмжээтэй нутгийн хуурамч өнгө бүхий NDVI зураглал: а) 2010 and б) 2011. Үхэл болсон нутгийг улаанаар хүрээлэн тэмдэглэв. Их утга нь ургамлын элбэгшил ихтэйг илтгэнэ. (ургамлын бүтээмжийг төлөөлүүлэн).

Сансрын зурагнаас жилийн тухайн үеийн урт хугацааны вариацийн цуваанаас үзэхэд үхэл болсон үеийн ургамлын бүтээмж болон чийгийн агууламж өөрчлөгдсөн болохыг илрүүлсэн. Сонирхолтой нь өмнөх жилүүдэд (2008 and 2009) хаврын сүүл үеэр бүтээмж болон чийгийн дундаж харьцангуй доогуур байсан. Ургамлын бүтээмж нь үрхэл болхо үед бөхөнд нөлөөлөөгүй хөрш зэргэлдэх газар нутгийн ажиглагдсантай адил байсан (Зураг 2). Ургамлын чийгийн агууламж нь хөрш зэргэлдээх газруудтай харьцуулахад үхэл болсон бүсэд харьцангуй доогуур байсан.

Зүйлийн бүрдлийг газар тус бүрээр ялгасан. Үхэл болсон нутагт хийсэн аюсан дээж кюадрат талбайд төллөх үеийнхээс илүү өөр хоорондоо илүү ижил төстэй байсан бөгөөд төллөх бүс нутагт нь зүйлийн бүрдэл харьцангуй өөрчлөлттэй байсан. (Диаграмм. 3). Үхэл болсон бүс нутагт ургамлын зүйлийн бүрдэл өндөр байсан. Цаашилбал хонхор газар нь


Өндөрлөг газар болон тэгш газраас зүйлийн бүрдлээр баялаг байсан. Бүх газраас авсан дээжинд АИР үүсгэх чадвартай L-тритопаны түвшин хангалттай их байсан.

Хэлэлцүүлэг

Бид 2011 оны тохиолдлын өмнөх хугацаанд ер бусын дулаан температур ажиглаагүй бөгөөд энэ нь бөхөнгийн үхэлд нөлөөлөх шалтгаан биш болохыг харуулж байна. Өмнөх өвөл нь хэвийн үеийнхээс хүйтэн байсан нь ургамлын шинж чанарт нөлөөлсөн эсвэл бөхөн эмзэгхэн хүлээн авдаг өвчинг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн байж болох нь ихээхэн сонирхолтой юм. Хэдийгээр энэ нь хур тунадасны уналтын өөрчлөлтөнд хүргэх боломжгүй ч орон нутгийн хүмүүс үхэл болохын өмнөх цаг агаар ер бусын чийгтэй байсан талаар мэдээлсэн. Гэсэн хэдий ч хэрвээ чийглэг уур амьсгал ургамлын чийгийн агууламж, бүтээмжийг өөрчилж чадсан бол NDVI юмуу NDWI аналizaар харагдах байсан. Хэдийгээр NDVI утга бусад жилүүдийнхээс, үхлийн бүс болон бусад бүс нутгийн хооронд онцын ялгаа ажиглагдаагүй ч навч/хөрсний чийг үхэл болсон газар болон хөрш зэргэлдээх нутгийн хооронд ялгаатай байсан нь бэлчээрийн өөрчлөлт үхэлд нөлөөлсөн байж болохыг харуулж байна. Цаашилбал бусад NDVI-тай холбоотой утгуудын туйлыг нээх хэрэгтэй. Мөн 2008 болон 2009 онд ургамолын бүтээмж болон чийг хэвийн үеийнхээс доогуур байсан бөгөөд дараагийн жилүүдэд бэлчээрийн хэв шинжийг бүхэлд нь өөрчилсөн. Сансрын зурагны бүдүүн тойм нарийвчлал нь ургамалжилтын нарийн хэмжээтэй өөрчлөлтийг илрүүлэхгүй байж болох талтай. Энэ нь идэш тэжээлээ сонгон хооллодог бөхөнд ихээхэн чухал юм.

Бидний бэлчээрийн судалгаа нь өмнө төллөсөн нутгийн бэлчээрийн АИР-ийг бодитойгоор индуклах байсаныг тэмдэглэх нь зүйтэй бөгөөд зүйлийн баялаг өндөр байх нь их хэмжээний энерги, шим бодисын боломжит байдлыг танинж болох бөгөөд гдаад шинж тэмдгийн нийлмэл байдлыг өөрчлөгч L-тритопан нь үүнийг бий болгоход чухал ач холбогдолтой. Эдгээр зөвхөн өвчнийг үүсгэн бий болгоход оролцож буй хүчин зүйл биш бөгөөд 2012 онд жилийн тухайн хугацаанд хийгдсэн судалгааны ажил хязгаарлагдмал байна.

Эдгээр үр дүн нь өнөөгийн таамаглалын ерөнхийлдөө тэмжиж байна.: зайнаас тандан судлах анализ нь ер бусын байгаль цаг уурын зарим зэргийг, үхэл болсон бүс нутгийн ургамлын чанарын өвөрмөц өөрчлөлтийг тогтоох явдлыг дэмждэг бөгөөд бэлчээрийн анализ нь үхэл болсон бүс нутгийн бэлчээр нь АИР-г бодитойгоор индукцлэх шаардлагатайг харуулж байна.



Диаграмм 3. 2010/2011 онд төллөх газар болон нүхэл болсон газарт хийсэн нийцлийн анализ. Цэг болгон нь нэг кюадратыг илэрхийлж байгаа бол өнгө бүр нь ялгаатай газрыг илэрхийлж байна: 2010 төллөлтийн бүс (хар), 2011 төллөлтийн бүс (цэнхэр), 2010 үхлийн бүс (ногоон) and 2011 үхлийн бүс (улаан). Бусад өнгийн цэгүүд нь ижил төстэй зүйлийн бүрдэл бүхий олон тооны квадратыг илэрхийлнэ.

Энэ асуудал нь батлагдаагүй бөгөөд илүү судалгаа хийх хэрэгтэйг баталж байна. Ялангуяа энэ нь ойрын жилүүдэд тохиромжтой хэмжээнд ургамлын өсөлт болон шим бодисын түвшинд уур амьсгалын төлөв байдлын нөлөөллийг тогтоох, үхэл болсон бүс нутгийн ургамлын бүлгэмдэл, хөрсний онцлогийг хэвийн бэлчээртэй харьцуулан нарийвчилсан судалгааг хийх чухал ач холбогдолтой.

Бэлчээрлэх хэв шинжийн мониторинг, төллөсний дараах ургамлын хэрэглээ нь бөхөнгийн бэлчээр ашиглалтыг илүү ихээр ойлгоход чухал ач холбогдолтой мэдээлэл болно. Энэ нь ирээдүйд тохиолдох үхлийг хэрхэн саармагжуулан багасгахыг сайн ойлгоход, жишээлбэл хэрвээ ургамлын АР индекс их өндөр болсон үед тухайн бэлчээрт хүрэх явдлыг хязгаарласнаар хүргэх болно.

Устюртын бөхөнг агнах эртний арга хэрэгсэл: аррансын үлдэгдэл

Жосеф Ю. Булл & Александр Есинов

Зөвлөх редактор: Жосеф Ю. булл, Их Британи, Эзэн хааны коллеж, Амьдралын ШУ-ны тэнхим,
j.bull10@imperial.ac.uk

1970 -1980 онд Устюртын өндөрлөгт хийгдсэн археологийн судалгаагаар В.Н.Ягодин зэв хэлбэртэй хана буюу аррансыг олж нээсэн. Энэхүү хачин жигтэй, These peculiar, том хэмжээтэй, ангийн байгууламж нь (Диар.1) нь онагер (*Equishemionus*), бөхөн, хар сүүлтий (*Gazellsubgutturosa*) болон Устюртын хонь (*Ovisvignei*)-ийг агнахад ашиглагдаж байжээ. Үүнтэй ижил төстэй байгууламж Алс дорнод, Европ, Америкт олдсон.

Арранс нь хэдэн арван га газрыг хамарсан чиглүүлэгч “өргөс”-өөр салаалсан юүлүүр хэлбэртэй хашаа юм. Шуудуу ухан хөрсийг малгаж, үүнийг дагуулан овоолсноор аррансыг хашаалан хамгаалдаг. Аррансыг газрын гадаргын онцлогт тохируулан хийдэг бөгөөд амьтны биологийн онцлог, ялангуяа тэдгээрийн нүүдлийн замыг сайн мэддэг анчдын мэдлэгийг харуулна. Агаарын гэрэл зурагнаас аррансын хэрхэн харагдаж байгааг мэдэхийн тулд бид GoogleEarth-ийн сансрын зурагнаас тэдгээрийг ялгахыг оролдсон. Олон удаагийн оролдлын үр дүнд бид Устюртын хойд хэсгийн зэв хэлбэртэй ханануудаас нэг арраныг олсон.



Зураг 1.
Сансраас “зэв хэлбэртэй” өнцөг хэлбэрээр харагдаж буй аррансууд (GoogleEarth-ээс авсан),
Узбек, Устюртын зүүн хойд хэсэг.

Энэ нь 2500 м-ийн өндрөөс хэвийн хэмжээг сонгоход бидэнд маш чухал байсан. Эцсийн дүнд бид бараг ижилхэн бүтэцтэй янз бүрийн өнцөг бүхий 50 орчим аррансыг сансрын зурагнаас илрүүлсэн. Сансрын зурагт зарим нэмэлт хэсгүүдийг хайх үйл ажиллагааны явцад сайжруулсан болон нэмэгдсэн аррансын зарим хэсгийг харуулж байна. Бүх аррансыг Узбекистаны Устюртын зүүн хэсгийн эгц цохио, Самын цөлийн зүүн төгсгөл (Казахстан), Тасай худгаас зүүн урд зүгт 25 км хол орших нутагт (Казахстан) буюу гурвалжин дотор тэмдэглэсэн.

Энэхүү гурвалжингийн талууд нь 130, 110, 100 км-ийн урттай болно (Зураг. 1).

Аррансууд нь 3 багананд хуваагдан байрлах ба ихэнх тохиолдолд хойд зүг рүү бага зэргийн гажилттай байсан. Хойд зүгт олдсон байгууламжийн зөвхөн цөөхөн хэсэг нь үндсэн чиглэлийн бусад хэсэг рүү харсан байв. Боломжт магадлал нь эдгээр ашаанууд нь бөхөн өмнө зүг рүү нүүдэллэх үед буюу намрын улиралд бөхөн агнахад хэрэглэдэг байв. Зэв хэлбэртэй хана идэвхгүй идэвхтэй гэсэн хоёр хэлбэрээр ажилладаг нь гайхалтай. d active

Эхний тохиолдолд өмнө зүг рүү нүүдэллэж буй амьтан хашаа руу орох үед анчид ирж тэднийг агнадаг байна. Идэвхтэй агналтын үед амьтныг арранс руу хөөн оруулж агнадаг байна.

Хамгийн сүүлд Хий болон газрын тосны компанийн байгаль үзүлж буй нөлөөллийг үнэлэх зорилгоор 2012 оны 6 сард Устюртад хийсэн НҮБХХ-ийн экспедицийн үеэр аррансын нарийвчилсан солбилцлыг олсон ба бид улсын хамгаалалттай газарт буй цөөн тооны байгууламжийг шалгах блонжийг ашигласан. Энэ нь зохих үр дүнгээ өгсөн бөгөөд өмнө эь бидний хэн ч нэг ч удаа хараагүй эхний арраны сүүл төгсгөл хэсгийг олсон.

Зэвний толгой хэсэг дээр зогсож байгаагаа тодорхой мэдэх хүртлээ бид юу ч анзаараагүй. Эхэндээ бид чулуун ханатай адил үарим нэгэн зүйл эсвэл түүнтэй төстэй зүйлийг байгааг таамаглаж байсан ч эргэн тойрон нэг ч чулуу байгаагүй. Тойргийн эргэн тойрон явж үзэхэд ургамалжилт огт өөр, газрын гадарга нь тэгш бус байсан ба бид арранс нь ухсан шуудуу хэлбэртэйгээр байж түүний зарим хэсэг маш сайн хадгалагдаж үлдсэн байхад зарим газартаа хэдэн арван см-ийн л гүн байна. Энэ нь олон зуун жилийн турш хадгалагдаж ирсэн нь үнэхээр гаухалтай. (Зураг 2.). Академич Ягодины үзэж байгаагаар Хойд Устюртын бүлэг аррансыг байгуулж ашиглах болсон нь манай эриний 1000 оны дунд үеээс эхэлсэн байна.

Бас нэг сонирхол татаж буй зүйл нь аррансын хэмжээ бөгөөд бүгд гоёмсог, зөв хэлбэр бүхий 31-43 га талбайг хамарсан шулуун өнцөгтэй, мөн ойролцоо хэмжээтэй байна. Нэг арраны шуудууны нийт урт нь 2,25 км байна. Маш их хөдөлмөр шингэсэн байгууламжийг барьж бүтээх, тэдгээр гайхалтай ангийн байгууламжийн ашиглаж байсан Устврт нутгийн хөрс зэгсэн хатуу байдаг нь уг зүйлийг барьж байгуулахад хамтран оролцсоны хүчинд ихээхэн ангийн дээжээр хариу барьж байжээ. Тэр ч байтугай агналт нь урт удаан хугацааны турш тогтвортой явагдаж байсан байх ёстой.



Зургаа Александр Басов

Зураг 2. Газрын гадарга дээр харагдаж буй арран.

Өнөөдөр үлдсэн нүхэнд бороо болон цасны ус хуримтлагдсанаас үүдэн тэдгээрийн ургамалжилт бусад хуурай газрынхаас ялгаатай бөгөөд *Artemisia terrae-albae-aar* баялаг байна. Энэ эрс тэс ургамалжилтын улмаас арраныг холоос харж чадна.

Хожим нь манай багийн нэг гишүүн болох Виктор Григорьев автоматаар зураг авах чадвар бүхий GoPro видео камер, 0,5 км өндөрт камерийг гаргаж чадах нисгэгчгүй нисдэг тэрэг шаардсан. Хайгуулын ажлыг Байгаль хамгаалах Витлейн сангийн дэмжлэгтэйгээр мотоцикл ашиглан бөхөнгийн мониторинг хийх явцад гүйэтгэсэн. Дээр тооцоолж байсанчлан арран нь нар жаргах үед гайхалтай харагдаж байсан. (Зур. 3).

Өнгөрсөн 2000 жилийн турш бөхөнгийн зан авир бага зэрэг өөрчлөгдсөн нь мэдээж бөгөөд бидний ажиглалтаар Узбекистаны бөхөнгүүд зэв хэлбэртэй хана олдсон газарт тогтмол үзэгддэг бөгөөд уг газарт эртний анчид томоохн хэмжээний хамтарсан анг хийдэг байжээ.

Өнөө үед мотоцикл унасан хулгайн анчид Устюртын бөхөнгийн популяцийн бууралтанд ихээхэн нөлөөлж байгаа бөгөөд бараг мөхлийн ирмэгт байна.

Хилийн төмөр утсан торийг 2012 онд босгосноор бөхөнгийн эртний нүүдлийн замыг хаасан байна. (БМ-15-аас хар). Энэ шинэ хашааг нурааснаар бэлчээрлэлтийг зогсоох зүйл юу ч байхгүй бөгөөд бөхөнгүүд өөрсдийн зуршил болсон нүүдлийн замыг даган амьдрах болно гэдэгт бид итгэлтэй байна.



Photo by Viktor Grigoryev

Зураг 3. Дээрээс харагдаж буй арран.

Зарлал

Жижиг тэтгэлгийн уралдаан, 2012

Манай 2012 оны жижиг тэтгэлгийн уралдааныг Зэрлэг амьтан хамгаалах сүлжээнээс ивээн тэтгэсэн. Энэ нь өвсний үндэс төслийн дэмжих бидний хийж ажлыг үргэлжлэл бөгөөд ЗАНЗХК-ийн бөхөн хамгаалал дээр хэрэгжиж буй Олон улсын дунд хугацааны ажлын хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тул эдгээр ажлуудыг чадавхижуулах явдал билээ. Энэ жил Орос болон Хятад улсаас 2 маш сайн төслийг дэмжих болсондоо бид баяртай байна.

Анатолий Клюдневийн төсөл нь хулгайн ангийн эсрэг багийг ашиглаж буй машиныг сайжруулан шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангаснаар Степной нөөц газрын ар талын чадавхижуулахад чиглэгдэж байна. Энэ нь хулгайн анг хянах тэдгээрийн боломжийг нэмэгдүүлэх ба ОХУ-ын Астрахан дүүрэгт бөхөн хамгааллын үйл ажиллагаа сайжрах юм. Уг төсөл нь мөн нутгийн хүмүүст экологийн мэдлэгийг түгээх замаар

олон нийтийн сурталчилгааны үйл ажиллагааг явуулна.

Фупинг Суны төсөл Хятадын Гуанжоу муж пахь бөхөнгийн бүтээгдэхүүний хэрэглээ, бөхөнгийн хууль бус худалдааг багасгахад чиглэгдэж байна. Уг төслийн үндсэн үйл ажиллагаа нь Хятадын Кингпинг удамдждат эмийн зах дээр 2009 оноос эхлэн Бөхөн хамгаалах нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр Хятадын Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн хэрэгжүүлсэн худалдааны мониторингийн ажлыг үргэлжлүүлэхэд чиглэнэ. Тэд хуулийн хэрэгжилтийг нутгийн иргэдэд таниулах, бөхөнгийн гаралтай бүтээгдэхүүний эргэн тойрон дахь хуулийн талаарх мэдлэгийг дээшлүүлнэ.

Бид ялагч нарт баярх хүргэхийн сацуу Бөхөнгийн мэдээний дараагийн дугаараас тэдний хийсэн ажлын тухай уншихыг тэсэн ядан хүзлээж байна. Хэрвээ хэн нэгэнд Жижиг тэтгэлэгт хөтөлбөртэй холбоотой ямар нэгэн тодруулга, санал зөвлөмж байвал редактор Елена Быковатай холбоо барина уу.

“Бөхөн гөрөөсний харилцан ойлголцлын санамж бичгийн зохицуулга, хэрэгжилтийг хангах” хурал болон Бөхөн хамгаалах нийгэмлэгийн жил тутмын уулзалт

НҮБХОХ/ЗАНЗХК-ийн нарийн бичгийн дарга нарын газар КБТЗХН, Бөхөн хамгаалах нийгэмлэгтэй хамтран **Казахстан улсын Астана хотноо 2013 оны 6 сарын 18-нд** болох ЗАНЗХК-ийн Бөхөнгийн харилцан ойлголцлын санамж бичгийн техникийн зөвлөлийн хурлын зарын хүргэхдээ таатай байна.

Хурлын зорилго нь Бөхөнгийн амьдах орчинд явагдаж байгаа дэд бүтэц байгуулалтын ажлын нөлөө, бөхөнгийн популяцийг хэрхэн сөрөг нөлөөллөөс ангижруулж чадах асуудлыг хэлэлцэнэ. Уулзалтаар 2011-2015 онд хэрэгжих Олон улсын дунд хугацааны ажлын хөтөлбөр, бөхөнгийн харилцан ойлголцлын санамж бичгийг зохицуулалтын талаар хийгдэж байгаа ажлын талаар хэлэлцэх бөгөөд холбогдох үзүүлэнг Бөхөнгийн мэдээллийн нөөцийн төвийн вэбсайтад байрлуулсан байгаа.

Дэлгэрэнгүй мэдээллийг хурлын орон нутгийн зохион байгуулагч болох КБТЗХН, Ольга Климановагаас емэйлээр (olga.klimanova@acbk.kz) болон факсаар (+7 727 220 3877) авна уу.

Уг хурлын дараа шууд үргэлжлүүлэн 2013 оны 6 сарын 19-нд Бөхөн хамгаалах нийгэмлэг өөрсдийн жил бүрийн ерөнхий уулзалтыг зохион байгуулах болно. Бөхөн хамгааллын үйл ажиллагаанд оролцох хүн бүрт уг хуралд оролцох нь нээлттэй бөгөөд БХН-ийн өнгөрсөн, одоо, ирээдүйн үйл ажиллагаа, түүний чиглэл, зорилгод хүрсэн үр дүнгийн талаар хэлэлцэх болно. БХН-ийн нарийн бичгийн дарга Елена Быковатай esipov@xnet.uz хаягаар холбогдон дэлгэрэнгүй мэдээлэл, оролцох тухай мэдээллээ бүртгүүлнэ үү.

Бөхөнгийн баатрууд



Зургийг Г.Сэлэнэ ДБХС Монгол дахь хөтөлбөрийн газар

Байгаль дэлхийгээ хамгаалж буй хүмүүсийг хүндлэн үнэлвэл зохистой. Байгалийг урамшуулж, бидний амьралыг баяжуулж, бидний сайн сайхан байхад хувь нэмрээ оруулан, экосистемийн үйлчилгээг дамжуулахын тулд бид амьдрах хэрэгтэй. Түүнчлэн ховор зүйлүүдийг хамгаалал нь улс орны үндэсний болон олон улсын өмнө хүдээсэн үүрэг хариуцлагыг биелүүлдэхэд чухал ач холбогдолтой. Бөхөн хамгаалагчдын сүлжээ (БХС) баг нь энэхүү эрхэм үйл ажиллагааны төлөө баруун Монголын Алтай Саяаны эко бүс нутагт идэвхтэй ажиллаж байна. Бөхөнгийн мэдээ БХС-ний удирдагч ноён Б.Батсайханыг танилцуулж байна.

Редактор: БХС анх хэзээ байгуулагдаж байсан бэ?

Б.Б.:Энэ нь 2007 оны 10 сард манай бөхөн хамгаалах төслийн хүрээнд дахин байгуулагдаж байсан. Манай БХС баг нь бөхөнгийн гол байршил нутаг болох Монголын баруун урд хэсэгт буюу Ховд, Говь-алтай аймгийн 11 суманд хамгааллын үйл ажиллагааг үр дүнтэй явуулж байна. БХС нь бөхөнгийн тархац нутгийн хүрээнд олон нийтэд мэдээлэл түгээх, экологийн мониторинг хийх зорилгоор 1998 онд 6 хүнтэйгээр байгуулагдаж байсан. Одоо бөхөнгийн тархац нутгийн хэмжээнд 13 байгаль хамгаалагчтай.

Редактор: сүлжээ байгуулагдахаас өмнө нөхцөл байдал ямар байсан бэ? Маш их хулгайн ан хийгддэг газар байсан гэж би төсөөлж байна?

Б.Б.:Таны зөв.Бид сүлжээ байгнгуулагдахаас өмнө хулгайн ангийн хэдэн тохиолдол, хэдэн амьтан алагдаж байсныг мэдэхгүй. Нэг зүйлийг хэлэхэд энд ямар нэгэн хяналт байхгүй, эргүүл байхгүй, эвэр болон бусад зэрлэг амьтны гаралтай эд эрхтнийг худалдаж авах зарлал ихээр түгсэн газар байсныг би мэдэж байна. Маш сайн зохион байгуулалттай, үр дүнтэй үйл ажиллагааны нөлөөгөөр БХС байгуулагдсаны дараа хууль бус антай холбоотой олон тооны зөрчил илэрсэн.

Редактор: Хүмүүс бол байгаль хамгаалах сүлжээний гол түлхүүр нь.Танай багийн гишүүдэд ямар сайн тал байна вэ?

Б.Б.:Манай байгаль хамгаалагчдын ихэнх нь бөхөнгийн тархац нутагт байнга оршин суудаг малчид. Тэдгээр нь бүгд БХС нь нөхөрлөлд тулгуурласан бүлэг учраас сайн дурын байгаль хамгаалагчдын багаар дэмжигдсэн байна. Тэд газар нугаа, амьтнаа сайн мэдэхийн сацуу тэдгээрийн хамгаалахад бие сэтгэлээ өгсөн хүмүүс, энэ нь бид илүү зүйл хийх боломжтой гэсэн үг. Манай сүлжээ 3 дэд багтай бөгөөд багуудын амжилтыг дээшлүүлэхийн тулд өөр хооронд нь өрсөлдүүлдэг. Баг нь бөхөнгийн тархац нутагт байнга эргүүл хийдэг нь хулгайн анчдыг айлгах, түүнчлэн орон нутгийн иргэдээс хөдөлгөөнт дэмжлэгийн авах нөхцлийг хангадаг.

Бүх байгаль хамгаалагч нар сургагдсан бөгөөд мотоцикл, радио холбоо, GPS, дижитал камер, дуран, ажлын зураг, дүрэмт хувцасаар хангагдсан. Бид монгол бөхөнгийн экологийн судалгааг сар бүр хийж заншсан бөгөөд багийнхны хэлэлцүүлгээр 7 хоногийн нарийвчилсан ажлын төлөвлөгөөг гарган ажилладаг. Энэ нь яагаад бидний ажил амжилттай байдгийн нууц. Тус баг нь бүс нутагтаа хүндлэл хүлээсэн, сайн сургагдсан, хүчтэй идэвхжүүлэгч баг юм. Энэ нь Монгол улсад байгаа хамгийн сайн, үр дүнтэй хууль хэрэгжүүлэх нэгжийн нэг юм.

Редактор: сүлжээнийхний илрүүлсэн хулгайн ангийн ямар өвөрмөц тохиолдол байна вэ?

Б.Б.:2007 оноос хойш орон нутгийн хууль схиулах байгууллага, хулгайн ангийн гэмт хэргийг илрүүлэх, буруутныг шүүхэд шилжүүлдэг “Ирвэс-3” багийн байгаль хамгаалагчтай нягт хамтран ажилласнаар 35 бөхөн хулгайгаар агнасан 7 тохиолдлыг илрүүлсэн. Мөн 8 удаагийн тохиолдлоор 44 бөхөн агнасан хэргийг илрүүлсэн боловч гэмт этгээдийг олж чадаагүй бөгөөд одоог хүртэл мөрдлөгийн үйл ажиллагаа үргэлжилж байна. Бөхөнгийн хууль бус агналтын зэрэгцээ бид мөн бөхөнгийн тархац нутаг болон хөрш зэргэлдээх газарт буй хар сүүлтэй, янгир, ирвэстэй холбоотой хэргийг илрүүлдэг.

Гэвч хэрэг илрүүлэх нь хагийн чухал ач холбогдолтой зүйл биш гэж би боддог. Хамгийн чухал зүйл нь ямар хэрэг гардаггүй хүрээлэн буй орчныг бүрдүүлэх явдал юм. Одоо үед байгаль хамгаалагч нар аюуд учруулж буй хүмүүст торгууль ноогдуулахаас илүүтэйгээр хамгаалал руу чиглэсэн малдчын бүлэг нөхөрлөлийг хэрхэн мэдээллээр хангах ажлыг мэддэг байх ёстой. Бид одоо эдгээр асуудалд голлон ажиллаж байна. Хяналт шалгалтын зэрэгцээ хүмүүст хууль бус анг зогсоох талаар ухуулга сурталчилгаа хийдэг. Ядахдаа бөхөнгийн тархац нутагт байгаа нөхөрлөл тэнд бөхөн хамгаалагч нар байдаг тухай мэдээллээр хангагдвал бидний ажлыг дэмжиж эхэлнэ. Иймээс орон нутгийн хүмүүстэй ажиллах нь зайлшгүй чухал юм.

Редактор: Танай багт нүүрлэж буй төвөгтэй асуудал юу байна вэ?

Б.Б.:Хүндрэлтэй асуудал байлгүй яахав. Бөхөнгийн эврийн эрэлт нт хулгайн анчдад муу зүйлийг бий болгодог. Бөхөнгийн эврийн худалдаа эрхэлдэг маш өндөр зохион байгуулалттай, нууц бүлэг байж магадгүй гэж бид сэжиглэж байна. Энэ бол бидэнд нүүрлэж буфй хүндрэлтэй асуудлын нэг. Зарим тохиолдолд хилийн боомтон дээр гаалийнхны хурааж авсан бөхөнгийн эврийн тухай бид мэдэхгүй өнгөрдөг жишээтэй.

Редактор: Хууль бус ан агнуур, бөхөнгийн эврийн худалдаатай тэмцэхэд хамгийн чухал зүйл нь юу вэ?

Б.Б.:Мэдээлэгчийг шагнаж урамшуулах асуудал хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох хамгийн сайн аргын нэг. Энэ бодлого бөхөнгийн тархац нутгийн хүрээнд өргөн хүрээтэй явагддаг. Хулгайн ангийн хэргийг илрүүлэхэд мөнгөн шагнал өгдөг. Өнөөг хүртэл бид бөхөнгийн хууль бус ангийн тухай чухал мэдээлэл өгсөн 8 хүнийг болон эдгээр хууль бус ангийн хэрэг дээр идэвхтэй ажиллаж байгаа 3 цагдаагийн ажилтныг шагнасан байна.

Редактор: Энэ олон жилийн турш таны хүрч чадсан гол үр дүн юу вэ?



Photo by Selenge G/WWP Mongolia

Батсайхан БХС-ийн байгаль хамгаалагчдын хамт.

Б.Б.:Бөхөн хамгаалах төслийн тайланд дурсанаас харахад бид популяцийн хэмжээг 40%-иар, тархац нутгийн хэмжээг 10 хувиар өсгөж чадсан байна Энэ нь бөхөнгийн өнөөгийн тоо толгой, шинэ нутагт тогтмол үзэгдэх болсоныг нөхөрлөлүүдийн хэлэлцүүлгээр багтагдсан. Жишээлбэл Дөргөний хүрэн талаас хойш сүүлийн хэдэн арван жил бөхөн байхгүй байсан нутагт 2008 оноос эхлэн сүрэг бөхөн үзэгдэх болсон байна. Энэ нь магадгүй бөхөн хамгаалахад малчид оролцож эхлэсэн, хуулийн хэрэгжилтийг амжилттай явуусаны эхний үр дүн байж болох юм. Нөхөрлөлийн боловсрол, мэдээлэл сайжирснаар тэд бидний үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах нь ихсэж байна. Тэд төрийн байгаль хамгаалагчидтай хамтрахаас илүүтэйгээр бидэнтэй зөвхөн бөхөн төдийгүй бусад байгаль орчны асуудал дээрч хамтран ажиллаж байна.

Редактор: Та чи бол хамгаалагч гэж их ярьлаа. Та зөвхөн бөхөн хамгаалагч биш гэж үү?

Б.Б.:Хэдийгээр бид бөхөн хамгаалах сүлжээнийхэн гэж дуудагддаг ч гэсэн, бидний ажил бол бүхэлдээ оур

байгаль хамгаалах ажил юм. whole. Энэ бол зөв гэж би бодож байна. Бид зөвхөн бөхөнг бус бусад ан амьтанг ч хамгаална.

Редактор: Бөхөнг хамгаалахын тулд эн тэргүүнд юу хийх хэрэгтэй гэж та бодож байна?

Б.Б.:Монгол бөхөн үнэхээр ховор амьтан. Хэрвээ хатуу ширүүн өвөл зэрэг байгалийн гамшиг байнга тохиолдвол тэд бүрмөсөн устаж магадгүй. Иймээс хамгийн түрүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатй арга хэмжээ бол бөхөнгийн тархац нутгийг тэлэх асуудал юм. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд тэдгээрийн нүүдлийн хэв маяг, тархац, идэш тэжээл, тэдгээрийн тархац нутаг тэлэх болмжийн талаарх судалгаа хийгдэх ёстой. Хоёрдпахь чухал асуудал нь бэлчээрийн хүрэлцээгүй байдал, бөхөнгийн тархац нутаг дахь мал сүргийн хэт өсөлтийг хязгаарлах шаардлагатай. Иймээс янз бүрийн байгууллага, нөхөрлөлийн олон талт хамтын ажиллагаа нь бөхөнгийн тархац нутаг дахь бэлчээрийн тогтвортой менежментийг шийдвэрлэж, ингэснээр мал сүрэг зэрэлэг амьтадтай дахин зэрэгцэн орших болно.

Талархал

Бөхөн хамгаалах нийгэмлэг сүүлийн 6 сарын туршид бидний үйл ажиллагааг дэмжсэн дараах хувь хүмүүст: Маржорие Паркер, Линда Табор-Бек, Стевен &Карин Чэйсе, Кеннон болон Боб Худсон, Майкл Хакет & Дэвид Хале, Чип Овен, Николас Гонзалез & Гонзалезийн гэр бүлийнхэн, Жулие Скардина, Жефф Флокен, Миннесотогийн амьтан хамгаалах сан, Жоан Бриджвүүд, Алисон Фуллер, Жоел Сарторе, Жуне Стурм, Ник Линдсэй, Жосеф Алфано, Гэвин Еванс, Дебора Чернеяко нарт чин сэтгэлийн талархлаа илэрхийлж байна.

Бид Узбекистаны бөхөнгийн тархац нутаг дахь бидний боловсрол олгох болон уран хатгамалын хөтөлбөрийг дэмжиж санхүүжүүлсэн Дисней Канада, харилцаа холбоог дэмжиж буй Зэрлэг амьтныг хамгаалах нийгэмлэгийн хамт олонд гүн талархлаа илэрхийлж байна. Мөн Бөхөн хамгаалах нийгэмлэгийн шинэ элекьрон шуудан болох Saiga Spotlight-ийг бүтээхэд өөрийн тусыг харамгүй өгсөн график дизайнер Майк Бромбергт онцгойлон талархаж байна. Мөн сэтгүүлийн шинэ дугаарыг ивээн тэтгэсэн байгууллагууд болох Руфффордын жижиж тэтгэлгийн сан, Зэрлэг амьтан хамгаалах сүлжээ, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Хятад дахь хөтөлбөрийн газарт талархаж байна.

Редакцийн зөвлөл.Хятад: А. Канг (akang@wcs.org)&Фенглиан Ли (fli@wcs.org)WCS China; Казахстан: Профессор А. Бекенов&докЮ.А. Грачев, Зоологийн хүрээлэн (teriologi@mail.ru), О.Климанова, Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг (olga.klimanova@acbk.kz); Монгол: докторБ.Лхагвасүрэн &Б. Чимэддорж, ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар (lkhagvasuren@wwf.mn; chimeddorj@wwf.mn); ОХУ: Профессор Ю. Арылов, Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтан судлах төв (kalmsaigak@elista.ru) &док А. Лушекина, Экологи эволюцийн хүрээлэн (rasmabcom@gmail.com); Узбекистан: Е. Бикова [Гүйцэтгэх редактор] &док А. Есипов, Амьтан, ургамлын генийн сангийн хүрээлэн (esipov@xnet.uz); Их Британи: Профессор Е.Ж. Милнер-Гулланд [зөвлөх редактор], Лондонгийн эзэн хааны коллеж (e.j.milner-gulland@imperial.ac.uk).

Бүх өгүүллийг бидний хэрэглэдэг 6 хэлний аль нэг дээр бичнэ үү. Өгүүллийг esipov@xnet.uz хаягаар эсвэл редакторуудын аль нэг рүү илгээнэ үү. Бид жилд хоёр удаа гаргадаг. Материалаа esipov@xnet.uz хаягаар эсвэл редакторуудын хэн нэгэнд илгээнэ үү. Сэтгүүл жилд хоёр удаа гардаг. Өгүүлэл бичих журмыг www.saiga-conservation.com хуудсаас эсвэл редакторуудаас англи болон орос хэл дээр авч болно. Хэрвээ танд асуулт гарвал өөрийн улсын Бөхөнгийн мэдээний редактортай эсвэл гүйцэтгэх редактор Елена Быковатай (esipov@xnet.uz) холбогдоно уу.

Энэ дугаарыг онлайн хэлбэрээр www.saiga-conservation.com, <http://saigak.biodiversity.ru/publications.html> болон <http://www.wildlifewarden.net/wcs/mini/saiga-chinese.pdf> сайтуудаас pdf форматаар, эсвэл хүсэлтийн дагуу сэтгүүл хэлбэрээр редакторуудаас англи, казах, хятад, монгол, орос, узбек хэл дээр авч болно.

График дизайныг Виктор Григориев, mooglik@mail.ru.